

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт				
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам				
2025 оны I улирал				
Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц
ЗГ-ын тогтоол				
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	"5.1.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/170 дугаартай албан бичгээр Artificial intelligence (AI) гэсэн нэр томъёог монгол хэлнээ орчуулах асуудлаар зөвлөмж хүссэн. Тус албанаас 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр уг нэр томъёог ""хиймэл оюун"" гэж орчуулахыг зөвлөсний дагуу нийтийн хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна. 5.2.Тус яамны албан ёсны цахим хуудасны монгол бичгийн хувилбарт 01 сарын байдлаар нийт 24 мэдээ хөрвүүлж нийтэлсэн. 5.3.Тус яамны хэвлэмэл хуудасны Монгол бичгээр хэвлэх эх загварыг Архивын ерөнхий газраар 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06/27 дугаартай албан бичгээр баталгаажуулан хэвлүүлэн авсан. Монгол бичгээр хөрвүүлэх программ хэрэглэх зөвшөөрөл гарсан үед хос бичгээр хөтлөхөд бэлэн. 5.4.Яамны албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгыг 2025 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган баталсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн түвшинг тогтоох судалгаанд хамрагдсан. 5.5.Яамны гадна хаягийг кирилл болон монгол бичгээр үйлдсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд болон төрийн нарийн бичгийн даргын нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлэн хэрэглэж байна."
2	2	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, нийт 6 албан хаагчийг өөрийн болон улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахаар 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03/106 дугаар албан бичгийг Удирдлагын академид хүргүүлсэн. Мөн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагчийг өөрийн төсвийн санхүүжилтээр суралцуулах хүсэлтийг Удирдлагын академид 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03/638 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт : 1 файл

3	3	"Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2022-04-06 Дугаар 2022_143	2. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай. 2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийн зураг төслийг боловсруулах болон барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах болон гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт даалгасугай.	Хот барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 120 дугаар тушаалаар байгуулагдсан Шинэ Зуунмод хот болон Эдийн засгийг чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих төслийн хамтарсан зохицуулах хороо болон уг зохицуулах хорооны үйл ажиллагаанд шаардагдах судалгаа, тооцоо, мэдээллийг бэлтгэх, байгууллага хоорондын уялдаа холбоог зохицуулах, санал, зөвлөмж боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хуралд оролцож, уг ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөнд санал өгч, батлуулсан.
4	4	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022_187	1.5.. Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах төрийн байгууллагын дуудлагын утсыг нэгтгэх болон цахимаар хүлээн авах техникийн шинэчлэл хийх, түүнд шаардагдах хөрөнгийг тооцож жил бүрийн улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусгаж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт.	Төрийн байгууллагын 13,396 ширхэг суурин утсыг нэгтгэн "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-ийн холболтыг шугамд холбох техникийн шийдлийг үндэслэн Засгийн газрын 2022 оны 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журамд нэмэлт өөрчлөлт оруулах журмын төсөл, холбогдох саналын талаар 07 дугаар сарыг 07-ны өдөр хурал зохион байгуулж Тагнуулын ерөнхий газарт танилцуулсан.
5	5	Журам батлах тухай 2022-05-31 Дугаар 2022_219	2. "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 219 дүгээр тогтоолоор "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ыг баталсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас улсын төсвийн хөрөнгө, гадаад улсын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 29 цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг бүртгээд байна.

6	6	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Тус яамнаас “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийн санал авах тухай 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/2668 дугаар албан бичгийг харьяа байгууллагуудад хүргүүлэн саналыг нэгтгэж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03/72 дугаар албан бичгээр төлөвлөгөөний төслийн саналыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
	7		3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Тус яамнаас “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийн саналыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03/72 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
	8		5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагын-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсан. ТЦҮЗГ нь 21 аймагт хэлтэстэй ба нийт орон нутагт 52 салбар байгуулагдан ажиллаж байна.

7	9	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	9. Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг нэгтгэж, мэдээлэл солилцооны цахим шилжилтийг нэвтрүүлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, холбогдох мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасугай.	1.Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж болох 785 үйлчилгээ (лавлагаа тодорхойлолт 106, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариугаа өгөх боломжтой үйлчилгээ 144, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 535)-нээс 43 байгууллагын 478 үйлчилгээг төрийн үйлчилгээний цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна. 2. "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжүүлж байгаа программ хангамж, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор "Digital First-D1" арга хэмжээг "Цахимд хэвшье" уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажилласан. Ажлын үр дүнд төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сурагч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт 30,000 иргэн цахим ур чадвар олгох сургалт, экспо арга хэмжээнд хамрагдсан.
8	10	Жагсаалт батлах тухай 2022-12-14 Дугаар 2022_460	2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан XVIII.1.4 Үүрэн холбооны сүлжээ /Баянхонгор/ төсөл, арга хэмжээ 2024 онд шилжин хэрэгжинэ. Тус төсөл гүйцэтгэхээр тендерт шалгарсан "Мянган өндөр цахир" ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулан ажилласан. Гүйцэтгэгч "Мянган өндөр цахир" ХХК -аас 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/199 дүгээр албан бичгээр гэрээний дагуу ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн бөгөөд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулах талаар албан бичиг ирүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 07-ноос 15-ны өдрүүдэд байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, төслийн 6 цэгийг Байнгын ашиглалтад оруулах улсын комиссын 2023 оны ББКД-64-39/23, ББКД-64-38/23, ББКД-64-37/23, ББКД-64-37/23, ББКД-64-03/24, ББКД-64-02/24 дугаартай дүгнэлтээр хүлээж авсан бөгөөд төслийн эхний санхүүжилт болох нэг тэрбум төгрөгийг Монгол Улсын Засгийн газрын 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу "Мянган өндөр цахир ХХК'' -ийн эцсийн санхүүжилтийн материалыг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд 2024 оны 07 сарын 09-ний өдрийн 03/1407 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

9	11	Улаанбаатар хотын "Шинэ тойрог зам"-ыг барьж байгуулах тухай 2022-12-21 Дугаар 2022_476	5. 5.Авто замын чигийн дагуух ногоон байгууламж, инженерийн болон цахилгааны шугам, сүлжээ, гэрэлтүүлэг, холбооны кабелийг зөөх, шилжүүлэх, хүчитгэх, хамгаалах ажлыг 2023 оны 4 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт, уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар Улаанбаатар "Шинэ тойрог зам" барих төслийн 55км автозамын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нээлттэй зарласан. ХЗТ автозам ХХК-тай 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдөр гэрээ байгуулсан байна.
10	12	Агентлаг байгуулах тухай 2022-12-28 Дугаар 2022_499	8. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсантай холбогдуулан нийслэл, орон нутгийн "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийг нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбогдож төрийн үйлчилгээ үзүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /оператор/-ийг ашиглан 43 байгууллагын 451 төрлийн үйлчилгээг нийслэлийн 145 цэг, орон нутгийн 313 цэг, хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрын 31 улсын 47 цэг, нийт 505 цэгээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэн ажиллаж байна.
11	13	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	4. Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, хяналт шалгалтыг давхардуулахгүй, бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийг шинэчилж, хэвийн, аюулгүй байдлыг ханган хариуцаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/08 дугаартай "Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай" тушаалаар баталж, Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд 36 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 25 албан шаардлага, 6 улсын байцаагчийн зөвлөмж гарган хүргүүлж, зөрчил гаргасан 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулсан ба "Түгээмэл шуурхай шуудан" ХХК-ны Орхон аймаг дахь салбарын үйл ажиллагааг улсын байцаагчийн шийдвэрээр зогсоох арга хэмжээ авч ажилласан байна. Хяналт шалгалт, бүртгэл мэдээллийн www.shilenkhyanal.gov.mn системийн сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлын тендерийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр нээлттэй зарлаж (tender.gov.mn)-д байршуулсан. Тендерийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 10:30 цагт нээсэн ба гүйцэтгэгчээр "Интерактив" ХХК шалгарсан. Гүйцэтгэгч "Интерактив" ХХК-тай ЦХХХЯ/202310070 дугаар гэрээг байгуулан ажлыг гүйцэтгэсэн. 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдсэн.

12	14	“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	4. “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	Шинэ Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөөг гаргаж 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/438 дугаар албан бичгээр, мөн танилцуулгыг 2024 оны 04 сарын 12-ны өдрийн 01/780 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2024/02 дугаар бүхий ажлын даалгаврыг батлуулсан. Шинэ Хархорум хотын эхний ээлжийн мэдээлэл, харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн кабелийн ажлын зураг, төсөв боловсруулах ажлын өртөгт санал өгч ЦХИХХЯ-ны 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/385 албан бичгээр ХББОСЯ-нд хүргүүлсэн. Шинэ хар хорум бүтээн байгуулалтын үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгч 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Шинэ хар хорум хотын захиргаанд хүргүүлсэн. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
13	15	Дүрэм, журам батлах тухай 2023-02-01 Дугаар 2023_42	2. Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2023 оны батлагдсан төсөв, орон тоондоо багтаан хэрэгжүүлэх, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулж байхыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/72 дугаар тушаалаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн боловсруулж баталсан. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоог Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга, Орлогч дарга, Ахлах ажилтан, Кибер халдлага, зөрчлийн ажилтан, Кибер халдлага, зөрчлийн менежмент хариуцсан ажилтан, Санхүү хариуцсан ажилтан, Хатуу, зөөлөн дэд бүтцийн аюулгүй байдал хариуцсан ажилтан гэсэн 7 орон тоотой. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 42 дугаар "Дүрэм, журам батлах" тухай тогтоолын 2-т Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2024 оны зардлыг Сайдын багцад тусгаж 2024 оны улсын төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлсэн.

14	16	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;	Авлигатай тэмцэх “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Нэгдье” аяны зурагт хуудаст байгууллагын логог байрлуулан аянд нэгдэж буйгаа илэрхийлэн байгууллагын цахим хуудас https://mddc.gov.mn/mn/13368/ болон олон нийтийн сүлжээн дэх хуудаснууд, харьяа байгууллага болох Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ https://rtbn.gov.mn/%D0%B0%D0%B2%D0%BB%D0%B8%D0%B3%D0%B0-%D0%B0%D1%88%D0%B8%D0%B3-%D1%81%D0%BE%D0%BD%D0%B8%D1%80%D1%85%D0%BB%D1%8B%D0%BD-%D0%B7%D3%A9%D1%80%D1%87%D0%BB%D3%A9%D3%A9%D1%81-%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B8%D0%B4/ -ын олон нийтийн сүлжээн дэх цахим хуудаст зурагт хуудаснууд болон “Үгүй гэж хэлээд өөрчилье” видео шторкийг байрлуулсан. Тус яамны болон харьяа байгууллагын нийтийн албан тушаалтнуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой гарч буй эрсдэл, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, гэрээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, албан тушаалтанд хуулиар хүлээлгэсэн хориглолт, хязгаарлалтыг мөрдөх талаар албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд сургалт авах хүсэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/903 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад яамны болон харьяа улсын төсөвт үйлдвэрий газрын 60 гаруй албан хаагчдыг хамруулсан. Тайлан хүргүүлэх үеийн байдлаар тус яаманд төрийн албанд анх томилогдсон албан хаагч байхгүй болно.
	17		Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	Төрийн 87 байгууллагын 1263 үйлчилгээг 1,996,557 иргэнд e-mongolia, e-business, ХУРДАН цэг, ХУРДАН киоск, lavlagaa.e-mongolia.mn, мобайл аппликейшн гэсэн 6 үндсэн сувгаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж, чирэгдлийг багасгаж, хүнд сурталыг бууруулсан.

	18		Х-5.1. Цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох;	"Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэсэн "shilen.gov.mn" цахим системийг ашиглалтад оруулж, үндэсний хэмжээнд "Шилэн индекс"-ийг зарлан, 14 удаагийн хэвлэлийн бага хурлаар иргэдийг мэдээллээр ханган ажилласан. Нээлттэй мэдээллийн систем "shilen.gov.mn"-д 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар төсвийн нийт 5671 байгууллагаас нээлттэй мэдээлэл байршуулахаас 58% хувь буюу 3,288 байгууллагыг бүртгэж, 3579 албан хаагчдад нэвтрэх эрхийг олгон сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Тус системд 970,355 нэгж мэдээллийг байршуулж, хандалтын тоо 16 саяд хүрч, 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт тайлан илгээсэн 513 байгууллагын үнэлгээний дундаж үзүүлэлт 69 хувь, 2025 оны 1 дүгээр улиралд 1214 байгууллага тайлан илгээж, 238 байгууллагын үнэлгээг хянан баталгаажуулаад байна. Хуульд мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг "shilen.gov.mn" системд байршуулсан талаар 2023, 2024 онд нийт 4 удаа Засгийн газрын хуралдаанд болон Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар тус тус танилцуулж, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж байна."
	19		5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үндсэн орон тоог бүрдүүлэх зорилгоор Ажлын байрны сул орон тооны зарыг тухай бүр яамны цахим хуудсаар нээлттэй зарлаж, шалгалт авах ажиллагааг зохион байгуулж байна. Яамны үндсэн орон тоог бүрдүүлсний дараа харьяа байгууллага болон салбарын зарим байгууллагуудын албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргахаар ажиллаж байна. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харьяа хэлтсүүд 21 аймагт ажиллаж байна. Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, 3 операторын орон тоотой 21 аймагт 70 орчим ажлын байр бий болгон ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас

15	20	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	1. Аймаг, хотын цахим шилжилтийн түвшинг тодорхойлох зорилгоор “Цахим аймаг бодлогын зөвлөмж” болон аймгийн цахим шилжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 6 индекс 66 төрлийн үзүүлэлттэйгээр тогтоож, 2023 онд 21 аймагт аймагт томилолтоор ажиллан уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлсэн. Тус шалгуур үзүүлэлтэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх талаар тусгагдсан. 2. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжүүлж байгаа программ хангамж, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор “Digital First-D1” арга хэмжээг “Цахимд хэвшье” уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажилласан. Ажлын үр дүнд төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сурагч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт 30,000 иргэн цахим ур чадвар олгох сургалт, экспо арга хэмжээнд хамрагдсан бөгөөд хувийн хэвшлийн мэдээллийн технологи үйлдвэрлэгч байгууллага нь төрийн байгууллагатай хамтран ажиллах 14 гэрээ, 116 сая төгрөгний борлуулалт хийсэн
16	21	Журам, жагсаалт, загвар батлах тухай 2023-03-15 Дугаар 2023_100	2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.	“Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжүүлж байгаа программ хангамж, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор “Digital First-D1” арга хэмжээг “Цахимд хэвшье” уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажилласан ба цахим шилжилтийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулах, цахим боловсрол олгох сургалтад 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтан, төрийн 3,492 албан хаагч хамрагдсан байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь 21 аймагт Хурдан цэгийг байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Аймгийн иргэдэд жагсаалтад заасан үйлчилгээг тухай бүр шуурхай үзүүлж байна.

17	22	Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-03-29 Дугаар 2023_111	6. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд оюутанд зориулсан тусгай цэс бий болгож, номын сан, соёлын зэрэг үйлчилгээ авах, хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгасугай.	“Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжүүлж байгаа программ хангамж, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор “Digital First-D1” арга хэмжээг “Цахимд хэвшье” уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажилласан ба цахим шилжилтийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулах, цахим боловсрол олгох сургалтад 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтан, төрийн 3,492 албан хаагч хамрагдсан байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь 21 аймагт Хурдан цэгийг байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Аймгийн иргэдэд жагсаалтад заасан үйлчилгээг тухай бүр шуурхай үзүүлж байна.
18	23	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.4. “Ногоон хөгжлийн сэргэлт”-ийн хүрээнд Монгол орны бүс нутагт тохирсон төрөл зүйл модны үр, хөрсийг бий болгох, тарьж ургуулах технологи дамжуулах, нутагшуулах судалгааны сууриныг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулах, усны нөөцийн хадгалалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн цогц судалгаа хийх, ундны усны чанарыг сайжруулах, хаягдал ус цэвэрлэх, усны хэмнэлттэй технологи боловсруулах, байгальд ээлтэй дэвшилтэт технологи, ногоон санхүүжилтийн механизмыг бүрдүүлж, хог хаягдлыг дахин боловсруулах болон электрон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, устгалд оруулах технологийн шийдэл бүхий техник эдийн засгийн үндэслэлийг тус тус боловсруулж, танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Ногоон хөгжлийн сэргэлт”-ийн ажлыг эхлүүлсний үндсэн дээр тус яамнаас хамтран ажиллах боломжтой юм.
	24		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Ногоон хөгжлийн сэргэлт”-ийн ажлыг эхлүүлсний үндсэн дээр тус яамнаас хамтран ажиллах боломжтой юм.

19	25	Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт батлах тухай 2023-05-03 Дугаар 2023_164	2. 2.Улсын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн холбогдох хуульд заасан төрөлжсөн бүртгэл хөтөлж, сан үүсгэхийг холбогдох байгууллагуудад, уг бүртгэл хөтөлх үйл ажиллагааг цахимжуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.	Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн нэгдсэн системийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлснээр бүртгэх нөхцөл бүрдэнэ.
20	26	Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023-05-17 Дугаар 2023_178	2.2. Иргэн, хуулийн этгээдэд гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн үндсэн системээр дамжуулан авах, солилцох боломжтой мэдээллийг шаардахгүй байх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;	Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 109 хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Үүнд иргэн, хуулийн этгээдэд гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн үндсэн системээр дамжуулан авах, солилцох боломжтой мэдээллийг шаардахгүй байх талаар холбогдох хуулиуд болох Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулиуд багтсан. Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Инновац, цахим бодлогын Байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжсэн Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.” гэж заасны дагуу дээр дурдсан хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон уулзалтуудыг Хууль зүйн салбар, Эрүүл мэндийн салбар, Банк, санхүүгийн салбар гэсэн 3 чиглэлээр хийхээр төлөвлөж, “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” сэдэвт уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдөр, 03 дугаар сарын 26-ны өдөр боловсролын салбарын 500 орчим албан хаагч, эрүүл мэндийн салбарын 400 орчим албан хаагчдыг хамруулан зохион байгуулж арга хэмжээний үеэр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” сэдэвт илтгэл тавьсан.

21	27	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023-06-21 Дугаар 2023_233	1. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөрт багтаан цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (Т.Батбилэг), И-Монгол академи (Б.Мягмарнаран)-д тус тус даалгасугай.	Бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн этгээдэд зориулсан платформ И-Бизнес (e-business)-ийг 2023 оны 07 дугаар сард 800 үйлчилгээтэйгээр хэрэглээнд нэвтрүүлсэн. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд нийт 251 тусгай зөвшөөрлөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 43, эрх бүхий байгууллага өөрийн системээр 116, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож байна.
	28		7. Өмнөговь аймгийн Цагаан хад суурьшлын бүс дэх нүүрс ачилт, буулгалтын талбайн үйл ажиллагааны шат дамжлагууд дээрх нүүрсний тоон хэмжээний мэдээллийг олборлогч, тээвэрлэгч компаниуд цахим системээр зэрэг хянах боломжийг бүрдүүлэх, нүүрсийг экспортод гаргах гаалийн бүрдүүлэлтийг цахимжуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т тус тус даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон "И-Монгол академи" УТҮГ-ын албан хаагчид 08 дугаар сарын 01-04-ний өдөр хүртэл Дорноговь аймгийн Замын-Үүд суманд албан томилолтоор ажиллаж Хилийн боомт дахь хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны зураглал хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон. Мөн Засаг даргын Тамгын газарт ажиллан цахим шилжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үндэслэн Замын Үүд суманд цахим шилжилт хийх төслийн баримт бичгийг, төсвийн төсөөллийн хамт боловсруулсан. Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 23/247 дугаар албан бичгээр "Хилийн боомтын мэдээллийн нэгдсэн систем"-д зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/2367 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. Хилийн боомтын захиргаанаас "Үндэсний дата төв" УТҮГ төв рүү сервер байршуулахтай холбоотой системийн дэд бүтцийн судалгаа, хур мэдээлэл солилцооны системээр дамжуулан мэдээлэл солилцох зориулалтын судалгаа хийгдэж байна.
	29		12. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас дээрх тогтоолтой холбоотойгоор өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын биелэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 03/1618 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл

22	30	"Журам батлах тухай" /Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх/ Засгийн газрын тогтоол 2023-07-05 Дугаар 2023_251	1. 2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд үүрэг болгосугай.	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд нийт 251 тусгай зөвшөөрлөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 43, эрх бүхий байгууллага өөрийн системээр 116, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас тоон гарын үсгийн гэрчилгээ олгодог ба Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/68 дугаар тушаалаар "Монпасс СА" ХХК-ийн тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2028 оны 07 сарын 29-ний өдрийг хүртэл сунгасан. Мөн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар баталсан. "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-д заасны дагуу мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдээс ирүүлсэн материалуудтай танилцан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар 2023 онд 12 хуулийн этгээдэд, 2024 онд 6 хуулийн этгээдэд зөвшөөрөл олгосон байна.
23	31	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу 2025 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын нийт 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах, эрх шилжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг www.publicinvestment.gov.mn цахим системд иж бүрэн, Төсвийн тухай хуулийн цаглабрын дагуу тайлагнаж байна.
24	32	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс тус яамны нийт албан хаагчдад 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр "Иргэн бүрт эрүүл мэнд"- ийн боловсрол олгох зорилтын хүрээнд ажлын байран дахь эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал, зуршил, хамт олны дотоод харилцаа, уур амьсгал сэдэвт сургалт зохион байгуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А116 дугаар тушаалын дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Хавдар судлалын үндэсний төв эмнэлэгтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 29, 06 дугаар сарын 15-ны өдөр "Ажилтны урьдчилан сэргийлэх багц" үйлчилгээнд хамрагдсан. Илрүүлэг үзлэгт эрэгтэй 32, эмэгтэй 53, нийт 85 албан хаагч хамрагдсан.

25	33	“Их өгөгдлийн (big data) сан” үүсгэх тухай 2023-11-08 Дугаар 2023_403	1. Үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Их өгөгдлийн (big data) сан”-г үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээг Үндэсний статистикийн хороотой хамтран хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүний үр дүнд нийгмийн даатгалын мэдээллийн сан, нийгмийн халамжийн мэдээллийн сан, хүн амын өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, бизнес регистрийн мэдээллийн сан зэрэг 5 өгөгдлийн сангийн мета-өгөгдөл дээр боловсруулалт хийсэн. Тухайлбал, мэдээллийн сан тус бүрээс 1 сая мөр өгөгдлийн регистрийн дугаарыг шифрлэлтийн арга ашиглан татан авч, хоорондын нийцтэй байдал, мэдээлэл боловсруулах хурд зэргийг C, Python, Go зэрэг 3 төрлийн программчлалын хэл дээр туршсан. Туршилт амжилттай болсон.
	34		2. Энэ тогтоолын 1-д заасан санг үүсгэхдээ хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, хязгаарлалттай мэдээллийн хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах нөхцөлийг бүрдүүлэхийг “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газар (Б.Мягмарнаран)-т үүрэг болгосугай.	Хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга хэрэгсэл бүхий хэрэгсэл (tool) хөгжүүлэх ажлын хүрээнд өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscation, Generalization, Perturbation) – өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгслийг хөгжүүлж, тус хэрэгслийг Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт суурилуулан амжилттай туршсан. Мөн их өгөгдлийн сан үүсгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв УТУГ нь 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн.
	35		4. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулсан. Хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох зааврыг боловсруулсан. Мөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг цуглуулахад дэмжлэг үзүүлж ажилласан.
26	36	Жагсаалт батлах тухай 2023-11-22 Дугаар 2023_409	4.. Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хуулийн дугаар, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл арга хэмжээнд УТ2406700144, УТ2406700137, УТ2406700138, УТ2406700146, УТ2406700145-3, УТ2406700145-5 дугаарыг тус тус олгож, тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулсан.
	37		5. Тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус үүрэг болгосугай.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл арга хэмжээнд УТ2406700144, УТ2406700137, УТ2406700138, УТ2406700146, УТ2406700145-3, УТ2406700145 дугаар төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулахад үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэлийг тухай бүр авч, архивын нэгжид хадгалсан.

27	38	Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах тухай (2023 оны 484-р тогтоолоор өөрчлөлт орсон) 2023-11-22 Дугаар 2023_411	9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллах албан тушаалтан / тус яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/-т үүрэг болгож, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
28	39	ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-29 Дугаар 2023_419	5.. E-Mongolia цахим системд төрийн үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамж, санал, хүсэлтийг авах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia системийн аппликэйшн, портал, оператор 3 сувгаас үйлчилгээ авсан иргэн тухайн үйлчилгээг авсаны дараа сэтгэл ханамж, санал хүсэлтээ үнэлгээгээр илэрхийлэх боломжтой бөгөөд 2024.01.01-2024.10.01-ний өдрийн хугацаанд 658,825 үнэлгээ ирсэн байна. Нийт 2,260,330 үйлчилгээ авснаас 659,982 үнэлгээ ирсэн. Үнэлгээ өгсөн үйлчилгээнүүд харилцан адилгүй бөгөөд ихэнх нь лавлагаа тодорхойлолтын үйлчилгээ байна. Жишээлбэл Иргэний үнэмлэхний лавлагаа үйлчилгээг авахад иргэдийн 22.3% нь Маш хялбар гэж үнэлсэн бол 72.5% нь Хэцүүтэр, үлдсэн 5% нь бусад гэж үзсэн байна. Үйлчилгээний нэр Үнэлгээ Иргэний үнэмлэхийн лавлагаа Хэцүүтэр (3 оноо) 66751, Маш хялбар (7 оноо) 20594, Хялбар (6 оноо) 2577, Мэдэхгүй (4 оноо) 746, Маш хэцүү (1 оноо) 637, Хэцүү (2 оноо) 453 Дундаж (5 оноо) 248 гэж үнэлгээ өгсөн байна.
29	40	Түлхүүр үг батлах тухай 2023-12-06 Дугаар 2023_433	4.. Түлхүүр үгийг 2024 оноос хэрэглэж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг 2023 онд багтаан хангаж, бэлтгэл ажилд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт үүрэг болгосугай.	Түлхүүр үгийг 2025 оноос хэрэглэж эхлэхтэй холбогдуулан шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.
30	41	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483	2.11.. Дээрх төрийн орон сууцны дэмжлэгт хамруулах иргэн, өрхийг тодорхойлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, тодорхойлсон мэдээллийн санг цахим системд нэвтрүүлж, хэрэгжүүлэгч байгууллагууд тухай бүр хандах боломж нөхцөлөөр хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Үндэсний статистикийн хороо (Б.Батдаваа)-нд.	Монгол Улсын Засгийн газрын "Иргэдийг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай" 2023 оны 483 дугаар тогтоолын 2.11 дэх хэсэгт заасны дагуу төрийн орон сууцны дэмжлэгт хамруулах иргэн, өрхийг тодорхойлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг эрчимжүүлэх зорилготойгоор Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулсан уулзалтад 2024 оны 03 дугаар сарын18-ны өдөр оролцсон. Тус уулзалтаар тогтоолоор үүрэгжүүлсэн ажлыг хийхтэй холбоотой асуудлыг ярилцаж, ХНХЯ төрийн орон сууцны дэмжлэгт хамруулах иргэн, өрхийг тодорхойлсоны дараа ЦХИХХЯ мэдээллийн сан үүсгэх, мэдээлэл солилцохтой холбоотой асуудлыг хамтран шийдвэрлэхээр тохиролцсон. Мөн ХББОСЯ шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулан ажиллахаар тогтоод байна.

31	42	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41	3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.(1.“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.)	Фестивалийг зохион байгуулахад ЦХИХХЯам түүний харьяа байгууллагууд, үүрэн холбооны хувийн хэвшлийн байгууллагууд иргэдэд мэдээлэл, мессеж хүргэх зэрэг ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан.
32	43	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2024-01-31 Дугаар 2024_45	3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн мэдээллийг боловсруулж, бүртгэлийг цахимжуулан, мэдээллийг шуурхай солилцож ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (М.Энхсайхан) нарт тус тус даалгасугай.	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй хамтран и-монгол системийн мобайл аппликейншийн үнэт цаас хувьцаа цэсэд ногдол ашиг хэсэг нэмж, ногдол ашгийн он, ногдол ашгийн дүн, ногдол ашиг хүлээн авах данс зэрэг мэдээллийг харуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн мэдэгдэл явуулах интерфэйс (API) гаргасан. www.e-mongolia.mn
33	44	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар мэдээлэл хариуцагч байгууллагуудаас суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах хүсэлт ирүүлээгүй байна.

34	45	Журам батлах тухай 2024-03-06 Дугаар 2024_100	2.. Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус үүрэг болгосугай. ("Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам")	Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг үр дүнг Засгийн газрын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, "ХУР"-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. 2025.04.01-ний өдрийн байдлаар 415 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд эрүүл мэндийн нийт 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 17 сая мэдэгдлийг хүргэж, 1.3 сая хандалтыг авсан. "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. 2025 онд ЭМЯ-тай хамтран эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлыг Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр эхлүүлээд байна.
35	46	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3.Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тус яаманд ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалт төлөвлөөгүй болно.
36	47	Багшийн гурван тулгуурт бодлого цогц арга хэмжээг батлах тухай 2024-05-01 Дугаар 2024_192	3.. Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ"-г хэрэгжүүлж, багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд салбараас хамаарах шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай	"Багшийн гурван тулгуурт бодлого"-ын зорилго нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эхлүүлэн, зохион байгуулж байна. Энэ хүрээнд "И-Монгол академи" УТҮГ, Нийслэлийн боловсролын газартай хамтран сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд зориулсан сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. https://www.facebook.com/share/p/AspoeScTThzcKW9P/?mibextid=WC7FN e

37	48	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглалтад орохоор эрхлэх асуудлынхаа хүрээнд нэвтрүүлэн ажиллахаар бэлтгэж байна. Одоогоор тус систем ашиглалтад ороогүй байгаа болно.
38	49	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	2.. Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдол одоогоор ирээгүй болно.
	50		3.. Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэг болон киоск машинаар дамжуулан олгох боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (П.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай	Нийслэлд 144 цэгээс 12 ХУРДАН цэгээр дамжуулан нийт 16,250, орон нутагт 53 цэгээс 21 ХУРДАН цэгээр дамжуулан 38,650 иргэнд тоон гарын үсэг олгоод байна.
	51		4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Албан бичиг солилцооны дундын систем DocX-ээр дамжуулан 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 2,585 байгууллага тус системтэй холболт хийн 165,560 бичиг илгээж, 198,926 албан бичиг хүлээн аваад байна.
39	52	Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_06	4.. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон ажилтнууд нь чиг үүргийн давхардалгүй байхаар яамны үйл ажиллагааг зохион байгуулах, яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчдыг томилох, чөлөөлөхөд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг баримталж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан ба 2024 оны 08 дугаар сард багтаан Засгийн газрын хуралд танилцуулахаар бэлтгэн ажиллаж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах албан бичгийг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/103 дугаар албан бичгээр 21 сайдад хүргүүлсэн. Тус яамны бүтэц, зохион байгуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/80 дугаар тушаалаар баталсан.

40	53	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10	2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнээс урсгалд зардалд 124 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 144 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн. Мөн Сангийн яамнаас сайдын багц төсөв хянаж байгаатай холбогдуулан нэмэлтээр шаардсан мэдээллийг тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна.
41	54	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1	3. Теле камерын хяналтын төвүүдийн үйл ажиллагаанд Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт даалгасугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар теле хяналтын камерын стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, теле хяналтын камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын төв, Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Тээврийн цагдаагийн алба, Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.
	55		4.Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Тус яаманд суурилуулсан теле хяналтын камер нь төрийн тусгай хамгаалалтын сүлжээнд холбогдсон.
	56		6. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг удирдан зохион байгуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, стандартыг холбогдох журмын дагуу батлахыг Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар)-т даалгасугай	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар теле хяналтын камерын стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, теле хяналтын камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын төв, Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Тээврийн цагдаагийн алба, Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 04, 28-ны өдрүүдэд хуралдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Теле хяналтын системийн техникийн шаардлага MNS 6423:2019 стандартыг судалж, тээврийн хэрэгслийн дүрс бичлэгийн камер болон цагдаагийн энгэрийн камер, түүнд тавигдах шаардлагуудыг хариуцсан чиглэлийн дагуу боловсруулж, стандартын төслийн эхний хувилбарыг гаргаад байна.

42	57	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж, журам батлах тухай 2024-09-25 Дугаар 2024_97_1	4. 4.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай.	"Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг баталсан. Зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Анхдугаар хуралдаанаар "Үндэсний зөвлөлийн хуралдааны дэг"-ийг батлуулах, "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг зохицуулах журам"-ын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Мөн 2025 оны ХААТ-д Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардал болон хуулийг даган гарах журмын төсөл боловсруулах зэрэг төсвийг тусган баталсан. Одоогоор ХААег зарлаж эхлүүлээд байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
43	58	Журам батлах тухай "Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам" 2024-10-09 Дугаар 2024_120_1	2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай)	2024 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, түүний харьяа байгууллагууд төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаа одоогоор хийгдээгүй болно.

44	59	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163	2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	ЗГХЭГ, Шадар сайдын ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Үндэсний дата төвийн хамарсан ажлын хэсгийг 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулж, ажиллаж байна. Үүнд: Нэгж лиценз бууруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулж, судалгааг авах 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/153 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон мэдээлэл хариуцагч нийт 60 гаруй байгууллагад хүргүүлсэн бөгөөд нийт 939 байгууллагаас судалгааг ирүүлснийг нэгтгэн боловсруулж, ажлын хэсэгт танилцуулсан. Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын алба, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн худалдан авах ажиллагааны газрын төлөөлөл бүхий уулзалтыг нийт 2 удаа зохион байгуулсан бөгөөд уулзалтуудын үр дүнг 2024 оны 01/1302 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, шаардлагатай судалгаа мэдээллийг боловсруулах, Майкрософт компанитай санамж бичиг байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажил хангаж байна. 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг төслийг боловсруулж, хариуг хүлээж байна.
	60		3. Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай.	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвтэй хамтран Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх хүрээнд Кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" гуравдугаар шатны аяныг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд улсын хэмжээнд зохион байгуулсан. Тус сургалтад нийт 381 удаагийн сургалт зохион байгуулж нийслэл, 21 аймаг, 111 сумын 928 байгууллагын 24276 иргэний хамруулсан байна. Түүнчлэн Цахим зөв байя сургалтыг сурталчлан таниулах зорилгоор 25 фото мэдээ, 9 видео мэдээ, 27 контент, 3 постер тус тус хийж нийт 347743 хандалт авсан.
45	61	ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_164_01	1.. "Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагч, ажилтныг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, "	Тус хуулийн биелэлтийн хүрээнд хүсэлт гаргасан 1 албан хаагчийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны Б/61 дүгээр тушаалаар ажлын 5 хоногийн нэг өдөр цахимаар 2024.11.21-2024.12.31-ний өдрийг дуустал хугацаанд ажиллуулсан. Хавсралт : 1 файл

46	62	Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2024-11-20 Дугаар 2024_181	3.. Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгуулахаар тус яамнаас Дэлхийн шуудан холбооны дүрмийн арваннэгдүгээр нэмэлт протоколыг соёрхон батлах тухай, Шуудангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Сансрын тухай хууль (Анхдагч хуулийн төсөл), Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн тухай хууль (Анхдагч хуулийн төсөл), Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хариуцан боловсруулах талаар саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/344 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Үндсэн чиглэлд туссан хууль тогтоомжийг боловсруулах ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац харилуаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/39, 03 дугаар сарын 12-ны А/49 дүгээр тушаалуудаар байгуулсан ажлын хэсэг боловсруулж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хуульчид, олон нийтийн байгууллагын 40 гаруй төлөөллийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж энэ чиглэлд туссан хууль тогтоомжийг хэлэлцүүлсэн.
47	63	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27 Дугаар 2024_191_01	2.3.. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын дунд салбар хэлэлцүүлэг, "ICT EXPO-2025" үзэсгэлэнг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулсан.
48	64	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ хүн, хуулийн этгээдийг цахим гарын үсэг болон Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан таньж, баталгаажуулна" гэж заасны дагуу "Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар батлуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355322506031 Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 94 байгууллагын 179, хувийн 256 байгууллагын 300 систем, бүртгэлтэй 2,198,450 иргэн байна.

	65	2024-12-19 Дугаар 2024_217	3. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ хүн, хуулийн этгээдийг цахим гарын үсэг болон Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан таньж, баталгаажуулна" гэж заасны дагуу "Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 94 байгууллагын 179, хувийн 256 байгууллагын 300 систем, бүртгэлтэй 2,198,450 иргэн байна.
49	66	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024-12-20 Дугаар 2024_226	2. 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Агаарын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга болон нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.	Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар баталж, тодотгол хийж, зардлыг улсын төсөвт жил бүр шийдвэрлүүлж байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар Цагаан сарын баяраар хариуцлагатай жижүүрийг томилж, ажилласан талаарх илтгэх хуудсыг Төрийн ордны Онцгой байдлын албанд 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/568 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хэлэлцүүлэгт 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдөр оролцон мэдээлэл, харилцаа холбооны салбарын мэдээ мэдээллийг өгч ажиллалаа. Гамшгаас хамгаалах Улсын төлөвлөгөөг 2025 оны 2 дугаар улиралд Засгийн газраар батлуулж, улсын албадын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Улсын төлөвлөгөөтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, албадын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг алба хоорондын харилцан уялдаа, хамтын ажиллагааг хангах, эрчимжүүлнэ. Хавсралт : 1 файл
	67		2. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл, Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл, Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх "BPF-24mn" дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх гурван төсөл арга хэмжээнүүдийг батлагдсан техникийн тодорхойлолт болон үнэлгээний хороонд захиалагчийг төлөөлж үнэлгээний хороонд ажиллах албан хаагчдийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.

50	68	Жагсаалт батлах тухай 2024-12-25 Дугаар 2024_233	3. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл. арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код ("УТ" код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.	Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл (УТ2506700069), Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл (УТ2506700014), Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх "BPF-24mn" дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх (УТ2506700099) кодоор батлагдсанаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж ажиллаж байна.
	69		4. 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан ажиллаж байна.
51	70	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024-12-25 Дугаар 2024_238_1	2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг мөрдөн ажиллаж байна.
52	71	Цагааннуур" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2025-01-08 Дугаар 2025_09	2. 2.“Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсы.ч Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхпан. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт даалгасугай.	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2025 онд арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс

53	72	Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2025-01-08 Дугаар 2025_10	2. 2. “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай.	“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахаах төлөвлөж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
54	73	Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-02-05 Дугаар 2025_67	2. 2 .Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн “112” дугаарлалтад хүлээн авах техникийн нөхцөлийг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран бүрдүүлж, нэгдсэн дугаарлалтад шилжих системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн боловсруулах, хиймэл оюун ухаанд суурилсан технологийн шийдлийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг)-д тус тус үүрэг болгосугай.	Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой яаралтай тусламжийн дугаарыг нэгдсэн 112 дугаарт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Мэдэлэл, шуурхай удирдлагын төв, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн түргэн тусламжийн төв зэрэг байгууллагуудын хамтарсан уулзалтад 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр оролцож одоогийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Яаралтай тусламжийн үйл ажиллагаанд нэгдсэн 112 дугаарлалтыг нэвтрүүлэхэд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судлах”-аар туссан. Ажлын даалгаврыг батлуулсан бөгөөд үнэлгээний хороо байгуулж, худалдан авах ажиллагааг зарлахаар ажиллаж байна.
55	74	Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар батлах тухай 2025-02-12 Дугаар 2025_83	3. 3 .“Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Хийгдээгүй. 2026 оны төсвийн төсөлд санал оруулахаар бэлтгэж байна.

56	75	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	2. 2. Томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.	2026 оны төсвийн төлөвлөгөөнд томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тус тогтоолыг барин ажиллаж байна.
	76		4. 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	2026 оны төсвийн төлөвлөгөөнд томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тус тогтоолыг барин ажиллаж байна. Аж ахуйн нэгж, иргэнээс экспортын орлогыг нэмэгдүүлэх талаарх 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.
57	77	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-03-12 Дугаар 2025_132	1. Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Тус яам нь хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангаж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжиж төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй ажиллаж байна.
Ерөнхий сайдын захирамж				
58	78	Ажлын хэсэг байгуулах тухай 2022-02-07 Дугаар 2022_13	2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, хуульд заасан холбогдох журмын төслийг боловсруулах Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулж, Ажлын хэсгээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай. 2. Бэлтгэл ажлыг хангаж, холбогдох журмын төслийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Энх-Амгалан)-т даалгасугай.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 10 хуулийн хэрэгжилтийг тус яамнаас хангуулан ажиллаж байна. Энэхүү хууль тогтоомжоор эрх олгогдсон нийт 82 хэм хэмжээний акт /дүрэм, журам, стандарт/-ыг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах, мөрдүүлэх хүрээнд Засгийн газраас 26, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас дангаар болон бусад сайдтай хамтран 33 актыг баталсан. Үүнээс 2021 онд батлагдсан цахим шилжилтийг эрчимжүүлэх 4 багц хууль болон 2024 онд батлагдсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд хүрээнд 35 актыг боловсруулсан баталж, хэрэгжилтийг хангуулж байна.

59	79	Ажлын хэсэг байгуулах тухай 2023-01-27 Дугаар 2023_19	2. Төрийн байгууллагуудад хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Ажлын хэсгийн ажлын явц, үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т даалгасугай.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 19 дүгээр захирамжаар байгуулагдсан цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажлын үр дүнд салбар хоорондын зохицуулалтын нийт 17 ажлыг хийж гүйцэтгэн цаашид авах арга хэмжээг тодорхойлж 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/2212 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 46 дугаар тэмдэглэл батлагдаж, тус тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд мэдээллийн технологийн чиглэлээр салбар хоорондын зохицуулалтын талаар тогтоолын төсөл хэлэлцүүлж, батлуулсан.
60	80	Ажил хариуцуулах тухай 2024-03-14 Дугаар 2024_34	3.. Үндэсний зөвлөл, Үндэсний хороо, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлын хэрэгжилтийг зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн төслийг хуралдаан зохион байгуулснаас хойш 7 хоногийн дотор, үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Үндэсний зөвлөл, хорооны нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.	Кибер аюулгүй байдлын зөвлөлтйн дэд дарга, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Кибер аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулж, хуралдааны дэг, зөвлөлийн 2024 оны үйл ажллагааг хэлэлцэн баталсан. Хуралдааны мэдээллийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
61	81	2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2021-02-10 Дугаар 2021_9	XII.2. . Монгол Улсын Ерөнхий сайд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. “Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв”-ийг байгуулах, цаашид удирдан зохион байгуулах, Инновацын тухай хуулийн дагуу мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах, дээд боловсролын салбарт мэдээллийн технологийн өндөр түвшний мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухаан технологийн сангаар дамжуулан мэдээллийн технологийн компанийг дэмжих, “Боловсролын цахим шилжилт” арга хэмжээг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэж, зохих арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ) нарт даалгав.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Мэдээлэл технологийн үндэсний парк – National Information Technology Park дэмжлэгтэйгээр 2023 оны 08 дугаар сард ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалттай анги нээсэн. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж эцэслэн батлуулав. Хуулиар мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх талаар оруулж баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140722436571&sword=%D0%A1%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D1%80%D1%82,%20%D1%85%D1%8D%D0%BC%D0%B6%D0%B8%D0%BB%20%D0%B7%D2%AF%D0%B9

	82		XII.2. 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн компанийг олон улсын зах зээлд гарахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, гарааны бизнесийг дэмжих дундын хөрөнгө оруулалтын сан байгуулах чиглэлээр хувийн хэвшилтэй хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгав.	Бүгд Найрамдах Словени Улсын гадаад харилцааны яам, Монгол Улсын Гадаад харилцааны яам хооронд хамтран ажиллах төлөвлөгөөнд Мэдээллийн технологийн компанийн олон улсын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бүтээгдэхүүн үйлчилгээг нь сурталчлан таниулж хоёр улсын програм хангамж үйлдвэрлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах талаарх саналыг тусгуулахаар Гадаад харилцааны яаманд 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 03/764 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах ажлыг эхлүүлж, энэ ажлын хүрээнд салбарын хувийн хэвшлийн байгууллагуудыг долоо хоног бүрийн баасан гарагт хүлээн авч уулзаж байна. Мөн ЦХИХХЯ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын сан байгуулах ажлыг тусгаж, шаардлагатай санхүүжилтийг баталсан.
62	83	2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	XII.3. 8. Аялал жуулчлалын салбарт зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, цахим хэлбэрт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т;	Байгаль, орчин, аялал жуулчлалын салбарын энгийн зөвшөөрөл 40, бодит орчинд орсон 23, Тестийн орчинд орсон 1, хөгжүүлэлт эхэлсэн 3, бодлогын даалгавар боловсруулагдаж байгаа 13 зөвшөөрөл байна. /Гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны сан бүхий газарт ус, усан орчинтой холбоотой шинжилгээ судалгаа явуулах зөвшөөрөл, Нэн ховор амьтныг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнах, барих зөвшөөрөл, Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор амьтныг агнах, барих зөвшөөрөл, Харь ургамлыг байгальд тарималжуулах зөвшөөрөл /www.e-mongolia.mn/
	84		ҮIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; (“Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.)	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/64 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй 1 албан хаагч (Б.Бадамсүрэн)-ийг зайнаас буюу цахимаар ажиллуулж байна. Б.Бадамсүрэнийн эрүүл мэндийн нөхцөл байдал дээрдээгүй тул өөрийнх нь ирүүлсэн хүсэлтийн дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Б/63 дугаар тушаалаар зайнаас ажиллуулах хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийг дуустал хугацаагаар сунгасан.

2021 оны 6 дугаар сарын 8-ны
өдөр 34 дүгээр тэмдэглэл
2021-06-08
Дугаар 2021_34

ҮИИ.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Жендерийн үндэсний хорооны дүрэм", Жендерийн салбар зөвлөлийн ажиллах журамд заасны дагуу салбар зөвлөл нь харьяа агентлаг, байгууллагуудад дэд зөвлөлтэй байна. Дэд зөвлөл нь 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байна гэж тус тус заасны дагуу тус яамны ТНБД-ын 2024 оны 03/793 дугаар албан бичгээр харьяа салбар байгууллагуудад дэд салбар зөвлөл байгуулах, төлөвлөгөө тайлан гаргах чиглэлээр албан бичиг хүргүүлсэн. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, боловсруулах ажлын хэсгийн уулзалтад оролцсон. Жендерийн үндэсний хороонд эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлтэй танилцаж санал хүргүүлсэн. Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд салбартаа манлайлан ажиллаж буй 3 эмэгтэйн нэрийг хүргүүлсэн. МУ-ын Засгийн газар, Жендерийн үндэсний хорооны ажлын алба, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй, ""Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендерийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн жендерийн тэгш байдлыг сайжруулах нь төслийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсон. И-Монгол цахим платформд жендерийн үнэлгээ хийсэн, зөвлөмж тайланг тус яамны цахим хуудаст байршуулж олон нийтэд хүргэсэн. Мөн 2025 онд хийх ажлын төлөвлөгөө, төсвийн саналыг боловсруулж холбогдох газар уламжилсан. Монгол улсын ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан ""Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"" /2024-2027/-г үндэсний хэмжээнд танилцуулах арга хэмжээнд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга оролцсон.

Хавсралт : 8 файл

	86		ҮIII.5.5.. Цахим хуудас, телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг)-нд." гэжээ.	Харилцаа холбооны зохицуулах хорооноос хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, өргөн нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх хэсэгт "телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх" гэж заасан байдаг. Тус Хорооноос ӨНТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.5.4-т заасан хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлох чиг үүргийн дагуу МУ-д хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан гаргах үүргийг хүлээлгэсэн болно. Энэ нь дохионы хэлний хэлмэрчийн олдоц хязгаарлагдмал байдлыг харгалзан шат дараатай авч буй арга хэмжээний нэг юм. МУ-д хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлэгтэй арилжааны 26 нийт 47 телевизэд дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээлгэж байна. Харин арилжааны 13 телевизийн хувьд хэдийгээр МУ-д хамрах хүрээтэй ч спорт, кино, теле-худалдаа гм төрөлжсөн хөтөлбөртэй, хөтөлбөрт нь мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг байхгүй тул дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх дээрх телевизүүдийн тоонд ороогүй болно. Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн ТВ тоо, цаг. Нийт 55 ТВ /МУОНТ-5, ӨНТВ-18, АрТВ- 30/ нийт 6642:08:02 цагийн нэвтрүүлэг, Хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн ТВ тоо, цаг. Нийт 48 ТВ /МУОНТ-4, ӨНТВ-18, АрТВ- 26/ нийт 1924:29:20 цагийн нэвтрүүлгийг тус тус нэвтрүүлсэн байна.
64	87	2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл 2021-08-11 Дугаар 2021_46	ХҮII.7. . Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн ажлын явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Цахим шилжилтийн асуудлаар Эстони Улсын туршлага, жишиг загварыг ашиглах боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал тэргүүтэй харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төлөөлөгчид 2023 оны 09 дүгээр сарын 04-08-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Эстони Улсын Таллин хотноо зохион байгуулагдсан "Цахим Таллин Чуулган 2023" болон 8 дахь удаагийн "Нээлттэй засаглалын түншлэл" олон улсын чуулганд оролцож, Эстони Улсын Нийгмийн халамж, эрүүл мэндийн технологийн төв (ТЕНИК)-д зочилж, тус төвийн үйл ажиллагаа, Эстони Улсын эрүүл мэндийн технологийн дэвшил, үндэсний эрүүл мэндийн мэдээлэл солилцооны системийн талаар туршлагыг судалсан. Тус арга хэмжээний үр дүнгийн танилцуулгыг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1822 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

65	88	2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51	X.2.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны мэдээллийн сан болон төрийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг “Орон зайн мэдээллийн сан”-д оруулах, мэдээллийг нийтэд нээлттэй болгох ажлыг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас мэдээлэл хариуцагч нээлттэй байх мэдээллийг ил тод байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Байгаль орчин уур амьсгалын сан 1091 зөвшөөрөл, Байгаль орчны ерөнхий нөлөөллийн үнэлгээ 26.310, Барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлт 8,437, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 2,598 бүртгэгдсэн байна. Нийт 157.376 мэдээлэл нээлттэй байршиж, 15,758,721 удаагийн хандалт авсан байна.
66	89	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	“Бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн И-Бизнес платформ(e-business)-ийг 2023 оны 07 дугаар сард 800 үйлчилгээтэйгээр хэрэглээнд нэвтрүүлсэн. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдтэй холбоотой 832 үйлчилгээг нэгтгэж тус платформд нэгтгэж, 277,032 удаагийн үйлчилгээг платформоор дамжуулан үзүүлсэн байна.

67	90	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	ХҮИИ.2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх хүрээнд эрүүл мэндийн салбарт цахим шилжилт хийхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд даалгав;	Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. 2025.04.01-ний өдрийн байдлаар 415 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд эрүүл мэндийн нийт 25 үйлчилгээг нэвтрүүлэн ба 17 сая мэдэгдлийг хүргэж, 1.3 сая хандалтыг авсан. “Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ”-ний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. 2025 онд ЭМЯ-тай хамтран эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр эхлүүлээд байна.
68	91	2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27	ХҮИИ.3. . Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн цахим платформ нэвтрүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аялал жуулчлалын салбарыг дэмжих, гадаадын жуулчдад зориулсан мэдээллийн нэгдсэн цахим платформыг хөгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, цахим платформыг ашиглалтад оруулж, хөгжүүлэх, холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгав.	Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд "Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн цахим платформ" төслийн ажлын даалгаварыг ССАЖЯамаас боловсруулан ажиллаж байна.

69	92	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.1.2. Төрийн тусламж үйлчилгээ, лавлагаа мэдээллийн тусгай дугааруудыг нэгтгэн, нэгдсэн системээр мэдээлэл, тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт даалгав.	Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой яаралтай тусламжийн дугаарыг нэгдсэн 112 дугаарт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Мэдэлэл, шуурхай удирдлагын төв, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн түргэн тусламжийн төв зэрэг байгууллагуудын хамтарсан уулзалтад 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр оролцож одоогийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Яаралтай тусламжийн үйл ажиллагаанд нэгдсэн 112 дугаарлалтыг нэвтрүүлэхэд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судлах”-аар туссан. Ажлын даалгаврыг батлуулсан бөгөөд үнэлгээний хороо байгуулж, худалдан авах ажиллагааг зарлахаар ажиллаж байна.
	93		XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Монгол Улсын хэмжээнд 2025 оны 04 дүгээр сарын байдлаар иргэн, хуулийн этгээдэд нийт 1451595 тоон гарын үсэг олгогдсон байна. Тоон гарын үсгийн гэрчилгээг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тридумкей ХХК, Монпасс СА ХХК, НьюКомпас ХХК олгож байна. Тоон гарын үсгийг бүх төрлийн цахим үйлчилгээний системд нэвтрүүлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж, төрийн худалдан авах ажиллагаа, төрийн байгууллагын албан бичиг солилцоо, нийгмийн даатгалын үйлчилгээ, төрийн цахим үйлчилгээ, Эрүүл мэндийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, нийслэлийн тусгай зөвшөөрлийн систем, арилжааны банкуудын гэрээ байгуулах системүүдэд тус тус ашиглагдаж байна.

70	94	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А116 дугаар тушаалын дагуу албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Хавдар судлалын үндэсний төв эмнэлэгтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 29, 06 дугаар сарын 15-ны өдөр “Ажилтны урьдчилан сэргийлэх багц” үйлчилгээнд хамрагдсан. Илрүүлэг үзлэгт эрэгтэй 32, эмэгтэй 53, нийт 85 албан хаагч хамрагдсан.
71	95	2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл 2022-09-05 Дугаар 2022_44	II.2. Их өгөгдлийн (big data) сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох талаар Үндэсний статистикийн хороотой хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд нарт даалгав.	"Их өгөгдлийн (big data) сан үүсгэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох /ЦХХХЯ/20240203034/ зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгчээр ""СОФТ АССИСТ"" ХХК шалгарч, судалгааны ажлыг 100% гүйцэтгэж дууссан. "Их өгөгдлийн (big data) сан" үүсгэх тухай Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 403 дугаар тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Их өгөгдлийн сан үүсгэх туршилт хийгдсэн.
	96		I.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах саналаа танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав.	Тус яамнаас "И-Монгол академи" УТҮГ-т чиглэл өгч, Тагнуулын ерөнхий газраар "Албан бичиг солилцооны дундын систем (ДосХ)"-д мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийлгэсэн. Тагнуулын ерөнхий газраас 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ТЕГ03/173 дугаар албан бичгээр үнэлгээгээр илэрсэн эмзэг байдлууд, тэдгээрийн эрсдэлийн түвшинг тодорхойлсон зөвлөмжийг ирүүлсэн ба тус зөвлөмжийн дагуу уг системд холбогдох сайжруулалтыг хийсэн. Системийг шинэ дэд бүтэц рүү шилжүүлсэн. Аюулгүй байдал цэсэнд давхар хамгаалалттай нэвтрэх сонголтыг нэмсэн ба гар утасны бүх хувилбар дээр аппликэйшн ашиглах боломжтой болсон.

72	97	2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2022-09-14 Дугаар 2022_45	XX.4.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав;	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 53 дугаар тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг “Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгад шилжүүлэхтэй холбоотойгоор тус барилгын зориулалт өөрчлөх, технологийн шийдэл гаргах чиг үүрэг бүхий “дэд ажлын хэсэг” Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/56 дугаар тушаалаар байгуулагдан ажилласан ба уг ажлын хэсгээс шаардлагатай төсвийн тооцоолол болон тохижилт, засварын загварыг боловсруулан ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан. Түүнчлэн тогтоолд дурдагдсан байгууллагын удирдлага холбогдох албан хаагчидтай уулзаж, боломжуудыг судлахад нүүхэд гарах зардал өндөр, байгууламжийн эзэмшлийг шилжүүлэх боломжгүй, цаашид ашиглалтын зардал одоо байгаа зардлаас хэт өндөр тул нүүлгэн шилжүүлэх ажлыг дээрх зардлуудыг шийдэгдэх хүртэл тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.
	98		XX.4.3. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог нарийвчлан гаргаж, улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав;	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэхтэй холбоотойгоор шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог эхний байдлаар гарган ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан. Тус байгууламжид яамны болон харьяа байгууллага нүүхэд ашиглалтын болон захиргааны зардал хэт өндөр бөгөөд зөвхөн засварын зураг төсөв гүйцэтгэх зардалд 698 сая, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг байршуулах зардал 2.6 тэрбум орчим төгрөг гарахаар тооцоолсон болно. Иймд холбогдох зардлыг улсын төсөвт тусгуулах боломжгүй болсон.
73	99	2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46	Х.1. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрыг шилжүүлэх, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяанд Улсын бүртгэлийн ерөнхий газрыг шилжүүлэх боломжтой эсэхийг судлан үзэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	Улсын бүртгэлийн ерөнхий газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх боломжгүй талаар Ерөнхий сайдад танилцуулсан бөгөөд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг шинээр байгуулан салбар хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж байна.

74	100	2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48	XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд;	1.Цахим аймаг, хотын хөгжлийн жишиг загвар, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулан, 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2.Банкны холбоо болон 12 арилжааны банкны мэдээллийн технологийн албан хаагчдад “lavlagaa.e-mongolia.mn” системийн ашиглалтын талаарх сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Мөн Хүн, хуулийн этгээд үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийн эзний зөвшөөрлөөр хязгаарлалттай мэдээлэлд хандах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж lavlagaa.e-mongolia.mn системийг хөгжүүлсэн. “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 8.2 дахь хэсгийг үндэслэн “Үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ” байгуулсан. 3. Монгол Улсын Шадар сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 81/A/69 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс “Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага”-ын стандартыг боловсруулж, Техникийн хорооны хурлаар хэлэцүүлж, стандарт, хэмжил зүйн газрын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн C/51 тушаалаар MNS 6984:2022 баталсан. Стандартыг нээлттэй цахим номын санд байршуулан нийтийн хүртээл болгосон. https://mongolmedleg.org/books1/toriin-uilchilgee/
75	101	2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл 2022-10-19 Дугаар 2022_50	XII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.	Эдийн засаг, хөгжлийн яам хөрөнгө оруулагчдад зориулсан цахим үйлчилгээний нэгдсэн “e-invest” порталыг 2019 оноос хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг порталд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, татварын тооцоотой эсэх, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, хөрөнгө оруулагчийн тодорхойлолт авах зэрэг 6 байгууллагын 11 үйлчилгээг байршуулсан.
76	102	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Албан бичиг солилцооны дундын систем ДосХ-ээр дамжуулан 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 2,627 байгууллага тус системтэй холболт хийн 173,442 бичгийг 229,968 хавсралтын хамтаар илгээж, 207,488 албан бичиг хүлээн аваад байна.

77	103	2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн цахим системийн аюулгүй байдлыг хангаж, кибер халдлага, зөрчлөөс сэргийлж ажиллахыг Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг "И-Монгол академи" УТҮГ-ын захирал Л.Энхбатад тус тус даалгав.	Тус яамнаас "И-Монгол академи" УТҮГ-т чиглэл өгч, Тагнуулын ерөнхий газраар "Албан бичиг солилцооны дундын систем (ДосХ)"-д мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийлгэсэн. Тагнуулын ерөнхий газраас 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн ТЕГ03/173 дугаар албан бичгээр үнэлгээгээр илэрсэн эмзэг байдлууд, тэдгээрийн эрсдэлийн түвшинг тодорхойлсон зөвлөмжийг ирүүлсэн ба тус зөвлөмжийн дагуу уг системд холбогдох сайжруулалтыг хийсэн. Системийг шинэ дэд бүтэц рүү шилжүүлсэн. Аюулгүй байдал цэсэнд давхар хамгаалалттай нэвтрэх сонголтыг нэмсэн ба гар утасны бүх хувилбар дээр аппликэйшн ашиглах боломжтой болсон.
	104	2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2023-01-25 Дугаар 2023_5	Х.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийн тус яамны чиг үүрэгт хамаарах 6 арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1396 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Мөн "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д туссан 6 зорилтын биелэлтийн тайланг 96.67%-тай үнэлгээ хийж, Засгийн газарт тайлагнасан. Тодруулбал тухайн бодлогын баримт бичигт туссан тус яаманд хамаарах зорилт арга хэмжээний хэрэгжилт сайн биелэлттэй байна. Хавсралт : 1 файл
	105		Х.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	"1.Эдийн засгийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар байгуулсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөл боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, харилцаа холбооны чиглэлээр хэрэгжүүлэх төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, munkhsaikhan.d@med.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн. 2.Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн, боловсруулж, 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/89 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. 3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/677 дугаар бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.
	106		Х.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов.	Тус яаманд хамаарах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 31 арга хэмжээг 2024 оны жилийн эцсийн байдлаар 83,8%-тай үнэлэгдэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1400 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Хавсралт : 1 файл

	107		Х.3.. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхэлсэн асуудлын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 1 арга хэмжээг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган Төрийн мэдээллийн цахим сүлжээ (unelgee.gov.mn)-нд сар бүр тайлагнасан. 2024 оны жилийн эцсийн биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1395 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. 1.ЭЗХЯ-аас Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд дахин санал авч байгаатай холбогдуулан төлөвлөгөөний төсөлд салбарын танилцуулга болон төслийн тайлбар үндэслэлийг боловсруулж, 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 01/380 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд Үндэсний хиймэл дагуул төсөл, харилцаа холбооны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглан төрийн инновацийг хөгжүүлэх төсөл, мэдээлэл технологийн хаб байгуулах төсөл, аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх төсөл, нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах зэрэг нийт 11 төслийг тусгасан бөгөөд УИХ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн (35 дугаар тогтоол) чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан. 2."Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийн саналыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/98 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. 3.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг ЦХИХХ-ны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалаар баталсан. Уг ажлын хүрээнд ЗГҮАХ 2024-2028-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ болон холбогдох нэгжүүдээс ирүүлсэн саналыг оруулсан.
78	108	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл	ХИҮ.1.2. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн байгууллагуудын захиалгаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, "sudalгаа.gov.mn" үндэсний судалгааны нэгдсэн системийг хөгжүүлж, 2023 оны 6 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг "И-Монгол академи" УТҮГ ханган ажиллаж байна. Судалгааны санд 1018 хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд 1914 судалгааг нээлттэй байршуулсан байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар тус системд 11569 хандалт хийгдсэн байна. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэх ажлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар хариуцан ажиллаж байна.

	109	2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн байгууллагуудын захиалгаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, "sudalгаа.gov.mn" үндэсний судалгааны нэгдсэн системийг хөгжүүлж, 2023 оны 6 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг "И-Монгол академи" УТУГ ханган ажиллаж байна. Судалгааны санд 1018 хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд 1914 судалгааг нээлттэй байршуулсан байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар тус системд 11569 хандалт хийгдсэн байна. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэх ажлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар хариуцан ажиллаж байна.
79	110	2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8	XXXУ.11.2. "Цахим эрүүл мэнд" төслийг шинэчлэн боловсруулж, цахим шилжилтийг үргэлжлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт даалгав; 3."Цахим эрүүл мэнд" төслийг хэрэгжүүлэх явцад гарсан хууль бус үйлдэл, үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж шалгуулах, уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах этгээдээр прокурорын байгууллагыг оролцуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.	Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, "ХУР"-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. 2025.04.01-ний өдрийн байдлаар 415 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд эрүүл мэндийн нийт 25 үйлчилгээг нэвтрүүлэн, ба 17 сая мэдэгдлийг хүргэж, 1.3 сая хандалтыг авсан. "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. 2025 онд ЭМЯ-тай хамтран эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр эхлүүлээд байна.

80	111	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	III.6. Засгийн газрын бодлого, шийдвэр нийгмийн хүлээлттэй хэрхэн уялдаж байгаа талаар судалгаа хийж, гарсан дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэл бүхий тайлбар, холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг баталсан. Мөн тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа шинжилгээний хэлтсээс Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник технологид суурилсан төрөл бүрийн үйлчилгээнүүдийн талаарх судалгаа, Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааг хийсэн ба энэ талаарх мэдээллийг байгууллагын веб сайт хуудасны мэдээ цэсний, судалгаа дэд цэсэд байршуулсан. Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны цахим хуудаст Засгийн газрын бодлого шийдвэр, нийгмийн хүлээлттэй холбоотой олон мэдээ мэдээллийг мэдээ цэсэнд байршуулан ажиллаж байна.
81	112	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендерийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендерийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендерийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01 сарын 27-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Цахим хөгжил харилцаа холбооны салбарт баримтлах Жендерийн стратеги үйл ажиллагааны чиглэл /2023-2026/-г батлуулсан. 2.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 06 сарын 15-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар Жендерийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлуулсан. 3.Жендерийн эрх, тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/-ний 3.2.10-т И-Монгол цахим платформд жендерийн үнэлгээ хийж, зөвлөмж гаргах ажлын хүрээнд Судалгааны "ММСГ" компаниар И-Монгол цахим платформ ашиглагчдын насны бүлэг, хүйс, И-Монголиаг ашигладаг, болон ашигладаггүй оролцогчдын хүйс, байршил, ажил эрхлэлтийн байдал, өрхийн сарын дундаж орлого, гар утасны аппликейшн ашигладаг байдал, вэб сайт ашигладаг байдал, цахим ур чадвар, И-Монголиаг ашиглахад сэтгэл ханамжийн байдал, тулгамдаж буй хүндрэл болон шийдвэрлэх арга зам, Хурдан цэгээр үйлчлүүлж байсан эсэх, И-Монголиа шинэчлэлтийн талаар, цаашид нэмэх үйлчилгээний талаар, медиад өдөр бүр зарцуулдаг цаг, сошиал медиа хэрэглээ зэрэгт судалгаа, жендерийн үнэлгээ хийж, зөвлөмж гарган тайланг Жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн. 4.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ЦХХХ-ны салбарт ханган ажиллах салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан. 5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах, хөгжлийн бодлогын үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд, стратегийн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Жендерийн үндэсний хорооны дэргэдэх Бодлогын зөвлөлөөс санаачилсан Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилт үндэсний хэмжээнд гарч буй сайн туршлагатай танилцах, цаашид анхаарах асуудлаар 2025 оны 03 сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт ТНБД болон харьяа, салбар байгууллагуудын захиргааны дарга нарыг оролцуулсан.

	113		XII.2.3. Эрүүл мэндийн салбарын цахим системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, “ХҮР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХҮР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. 2025.04.01-ний өдрийн байдлаар 415 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд эрүүл мэндийн нийт 25 үйлчилгээг нэвтрүүлэн, ба 17 сая мэдэгдлийг хүргэж, 1.3 сая хандалтыг авсан. "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. 2025 онд ЭМЯ-тай хамтран эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр эхлүүлээд байна.
	114		2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчилж, хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, цахимжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар /Б.Баасандорж/, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав” гэжээ.	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчилсний дараа журмын дагуу систем үүсгэх ажил эхлэхээр байна.

82	115	2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14	XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: 3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт;	Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар бүх боломж нөхцөлийг судлан дэмжин ажиллаж байна. Одоогоор тус яамнаас олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагч байхгүй байна. Цаашид төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд магистр, докторын ахисан түвшний сургалтад хамрагдаж төгссөн төрийн албан хаагчдыг буцааж томилох, ажлын байраар хангах арга хэмжээг авч ажиллах болно.
	116		XVIII.7.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	"Мэдээллийн технологийн 1000 залуу инженер бэлтгэх" хөтөлбөрийн хүрээнд Tech4Good бүсийн уралдаанд Монгол Улсаас 10 иргэн /тус яамнаас 3 албан хаагч/ оролцсон. Тус арга хэмжээ 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр болсон. Мэдээллийн технологи харилцаа холбооны салбарын хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан нийгмийн асуудлыг шийдвэрлэх санаачилгаа олон орны залуус уралдуулж байна. Катар Улсын Харилцаа холбооны зохицуулах газрын ивээл дор Huawei компани 2023 оны "Ирээдүйн үр" хөтөлбөрийг зохион байгуулж байгаа бөгөөд Катарын Доха дахь Катарын Үндэсний конвенцийн төвд (QNCC) хэлэлцүүлэг өрнүүлсэн. Монгол, Катар, Саудын Араб, Кувейт, АНЭУ, Бахрейн, Казахстан, Пакистан, Оман, Узбекистан, Йордан, Ливан, Ирак, Азербайжан, Киргиз Улсын мэргэжилтнүүд тус арга хэмжээнд хамрагдсан.

83	117	2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2023-04-05 Дугаар 2023_15	XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав: Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг publicinvestment.gov.mn цахим системд тайлагнан ажиллаж байна.
----	-----	--	--	---

84	118	2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл 2023-04-12 Дугаар 2023_16	XIX.1. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махыг худалдан борлуулах цэгийг нэмэгдүүлэх, төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаалах цэг гаргах, аймаг, орон нутгаас мах ачсан тээврийн хэрэгслийг нийслэл хот руу саадгүй нэвтрүүлэх, нөөцийн махны чанарын асуудлаар мэдээлэл хийх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалант даалгав. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийх уулзалтын үеэр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг сурталчлан таниулж, хэрэгжилтийн явцын талаар мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. Төрийн ордны хашааны засварын асуудлаар иргэд, олон нийтээс ирүүлж буй шүүмжлэлийг харгалзан үзэх, засварын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, үйлдвэрийн захирлын асуудлаарх ажилчдын шаардлагыг нягтлан шалгаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалант, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав.	Тус яамны чиг үүрэгт хамаарах “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 54 заалтын хэрэгжилтийн тайланг 2 жилд 1 удаа, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн тайланг жилд 1 удаа тайлагнаж 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 03/53 дугаар албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчид Удирдлагын академиас зохион байгуулж буй “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах зорилго бүхий танхимын сургалтад, Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний сургалт болон шинэ сэргэлтийн бодлогын сургалтад яамнаас 3 албан хаагч тус тус хамрагдсан.
	119		XX.7. Эмнэлэгт өвчтөн илгээх 13А маягтыг цахимжуулах талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Эмнэлэгт өвчтөн илгээх АМ-13А, АМ-13Б, АМ-13В маягтыг цахим хэлбэрээр олгох нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав.	Эрүүл мэндийн яам тус маягтыг хэрэглэхээ болих шийдвэр гаргах хүртэл 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдөр хүртэл 6 сарын хугацаанд нийт 53,330 цахим маягт илгээгдсэн болно. Тус маягууд эрүүл мэндийн салбарт хэрэглэхгүй болсон тул энэхүү цахим системийг ашиглахгүй болсон.
	120		XIX.2.5. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэх асуудлыг судлан холбогдох саналаа боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалант, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг боловсруулах ажиллагаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хийгдэж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн хийж байна. Уг үнэлгээг үндэслэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэх асуудлыг судлан холбогдох саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна.

85	121	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.1.4. "Шинэ тойрог зам" төслийн урд хэсэг, Туулын авто зам болон Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох (Туулын авто замаас Нүхтийн авто зам хүртэл) авто замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгын ажлын нарийвчилсан зураг төслийг баталгаажуулахад шаардлагатай холбогдох техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Зам, тээврийн яам "Шинэ тойрог зам" барих төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж, гүйцэтгэгч харилцаа холбооны техникийн нөхцөл авах хүсэлт ирүүлсний дараа уг техникийн нөхцөлийг олгох асуудлыг шийдвэрлэнэ.
86	122	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19	ХҮIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. (Авлигын төсөөллийн индексийг тооцоход нөлөө үзүүлэх шалгуур үзүүлэлт (индекс)-ийг тодорхойлоход оролцдог байгууллагуудтай хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж, холбогдон гарах зардлыг судлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт)	Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэн тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна.
	123		ХҮIII.8.1. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;	Хилийн чанад дахь 31 улсын 47 төрийн үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд тус цэгүүдээр дамжуулан төрийн 43 байгууллагын 451 үйлчилгээг 9,662 удаа үзүүлсэн. www.khurdan.gov.mn
	124		ХҮIII.9. Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төслийг Сангийн сайдтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилтийн хүрээнд 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн бараа бүтээгдэхүүний худалдан авалт болон үйлчилгээний төлбөр төлсөн тухай бүр үйлдсэн төлбөрийн баримтын мэдээллийг автоматаар ибаримт системд бүртгэх үйлчилгээ 300 гаруй салбарт ашиглаж байна. Мөн эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулаагүй болно.

87	125	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажил 90%-ийн хэрэгжилттэй байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг нэгтгэн сар бүрийн 10-ны өдрийн дотор Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn -д оруулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлэгдэн 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1221 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Хавсралт : 1 файл
88	126	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэсэн “ shilen.gov.mn ” цахим системийг ашиглалтад оруулж, үндэсний хэмжээнд “Шилэн индекс”-ийг зарлан 14 удаагийн хэвлэлийн бага хурлаар иргэдийг мэдээллээр ханган ажилласан. Нээлттэй мэдээллийн систем “ shilen.gov.mn ”-д 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар төсвийн нийт 5671 байгууллагаас нээлттэй мэдээлэл байршуулахаас 58% хувь буюу 3,288 байгууллагыг бүртгэж, 3579 албан хаагчдад нэвтрэх эрхийг олгон, сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Тус системд 970,355 нэгж мэдээллийг байршуулж, хандалтын тоо 16 саяд хүрч, 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт тайлан илгээсэн 513 байгууллагын үнэлгээний дундаж үзүүлэлт 69 хувь, 2025 оны 1 дүгээр улиралд 1214 байгууллага тайлангаа илгээж 238 байгууллагын үнэлгээг хянан баталгаажуулаад байна. Хуульд мэдээлэл хариуцагч байгууллага байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг “ shilen.gov.mn ” системд байршуулсан талаар 2023, 2024 онд нийт 4 удаа Засгийн газрын хуралдаанд болон Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар тус тус танилцуулж, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

89	127	2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2023-06-07 Дугаар 2023_24	XXV.12.2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 151 дүгээр захирамжаар байгуулагдсан “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах салбар болон орон нутгийн хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох чиг үүрэг, үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэл боловсруулах Ажлын хэсгээс баталсан “2023 онд яам, агентлаг, харьяа байгууллагын эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Тус яамнаас “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төслийн саналыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03/72 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
	128		XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	Бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санаачилгаар 21 аймгийн цахим шилжилтэд тулгамдаж буй нийтлэг асуултуудад хариулт өгөх, орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн төвтэй засаглалыг хөгжүүлэх зорилгоор “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх, орон нутагт өндөр бүтээмжтэй, үр ашигтай эдийн засаг, нийгмийн гарцыг бий болгоход чиглэсэн мэдээллийн технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн, программ хангамжийг сурталчлан таниулах зорилгоор төр болон хувийн хэвшил хамтран “Digital First-D1” арга хэмжээг “Цахимд хэвшье” уриатайгаар 21 аймагт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 21 аймагт ажилласан. Ажлын үр дүнд төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сурагч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт 30,000 иргэн цахим ур чадвар олгох сургалт, экспо арга хэмжээнд хамрагдсан бөгөөд хувийн хэвшлийн мэдээллийн технологи үйлдвэрлэгч байгууллага нь төрийн байгууллагатай хамтран ажиллах 14 гэрээ, 116 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

90	129	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.3. Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ны хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав.	1.2024.12.09-ний өдрийн байдлаар 39 төрлийн 970,355 мэдээллийг байршуулж, 15,758,833 удаагийн хандалтыг авсан. 2. Шил ажиллагааны хэрэгжилтийг 2023.04.05, 05.31, 08.16 болон 2024.04.17-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд нийт 4 удаа танилцуулж, холбогдох төрийн байгууллагад чиглэл хүргүүлсэн. 3. ЕС-ын 2023 оны 01 дүгээр албан даалгаварын, биелэлтийг "Хангалттай" гэж үзэн 2023 оны 01/1174 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.4. Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн 6,090 хуудас мэдээллийн архивын материалыг бэлтгэн, нийт мэдээллийг машинд уншигдах хэлбэрээр бэлдэж 2023 оны 01/2240 дугаар албан бичгээр АТГ-т, хэрэгжилтийг УИХ-д танилцуулахаар 2024 оны 01/858 дугаар албан бичгээр ЕСАА-нд, мөн 2024 оны 01/1142 дугаар албан бичгийг ЗГ-ын гишүүд, аймаг, нийслэлийн ЗД нарт, "Шилэн индекс"-ийг үнэлгээг хянан баталгаажуулах, холбогдох сургалтыг зохион байгуулах чиглэлийг 2024 оны 01/1147дугаар албан бичгээр ТЦҮЗГ-т тус тус хүргүүлсэн. 5. АМТ зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны сүүлийн үеийн (GPT) технологийг сургаж, ашиглалтад оруулсан. 6. 2.0 системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 01/817 дугаар албан бичгийг ЗГ-ын гишүүд, Аймаг, Нийслэлийн ЗД нарт, шил ажиллагааны хүрээнд хамтран ажилласан 123 байгууллагын 257 албан хаагч нарт цахим шуудангаар хүргүүлж, 2024.12.09-ны өдрийн байдлаар хандах эрхийг мэдээлэл хариуцагч 1328 байгууллагын 1569 албан хаагчдад үүсгэж, 6 удаагийн сургалтад хамруулсан. 7. ХҮР систем, тусгай зөвшөөрлийн license.mn системүүдийг холбосон. 8. ЦХИХХЯ эрхэлсэн асуудлын хүрээнд салбарын байгууллагуудын Шилэн индексийн үнэлгээ, нээлттэй мэдээллийг бүрэн байршуулсан. ЦХИХХСайдын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 01/924 тоот албан бичиг ЗГ-ын гишүүд болон аймаг, нийслэлийн ЗД, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар буюу нийт 45 байгууллагад хүргэгдсэн. Мөн 01/983 тоот албан бичгээр ажил эрчимжүүлэх чиглэлийг ТЦҮЗГ-т хүргүүлсэн.www.shilen.gov.mn
	130		2.. Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;	"Цахим ур чадвартай 1000 боловсон хүчин" бэлтгэх хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй Grow with Google хөтөлбөрийн нээлт 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр болсон. Google компани Монгол Улстай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд Google компанийн албан ёсны эрхтэйгээр хэрэгжиж буй Google Career Certificate сургалтын агуулгад Их өгөгдөл, Мэдээллийн технологи, Цахим аюулгүй байдал, Цахим худалдаа, Төслийн удирдлага, UX design зэрэг 6-н чиглэлээр нийт 3-5 сар хугацаатай 350 мэдээлэл технологийн ажилтан хамрагдаж 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд Grow with Google хөтөлбөрийн оролцогчдод батламж гардуулах үйл ажиллагаа болж эхний ээлжийн суралцагч нар амжилттай төгслөө. Энэ хөтөлбөр Монгол Улсад анх удаа хэрэгжиж "Google Career Certificate"-ийн 1.2 сая төгрөгийн үнэ бүхий цахим сургалт, 40 цагийн танхимын сургалт, 30 цагийн ажлын байранд бэлдэх хөтөлбөрийг багтаасан ба оролцогч бүрт 3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

91	131	2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2023-07-05 Дугаар 2023_28	3.. Цахим ур чадварыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллахыг Харилцаа, холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг /;	"Харилцаа холбооны зохицуулах хороо, "И-Монгол академи" УТУГ хамтран ""БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАР ҮНДЭСНИЙ АЯН""-ыг өрнүүлж байна. Мөн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр "Хүүхэд таныг хамгаалъя" нээлттэй өдөрлөгийн хүрээнд Мэдээллийн технологийн мэдлэг, Ур чадвар талаарх мэдээлэл,Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, Цахим орчны зохистой хэрэглээг таниулах,Мэдээллийн аюулгүй байдал, Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт, Цахим орчинд үйлдэгддэг гэмт хэрэг, Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж зааварчилгаа өгөхийн зэрэгцээ E-Mongolia болон хүүхэд хамгааллын E-KIDS цонхыг хэрэглэх заавар, зөвлөгөөг хүргэсэн. www.e-mongolia.mn 2. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвтэй хамтран Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх хүрээнд Кибер аюулгүй байдлын ""Цахимд зөв байя"" гуравдугаар шатны аяныг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд улсын хэмжээнд зохион байгуулсан. Тус сургалтад нийт 381 удаагийн сургалт зохион байгуулж нийслэл, 21 аймаг, 111 сумын 928 байгууллагын 24276 иргэний хамруулсан байна. Түүнчлэн Цахим зөв байя сургалтыг сурталчлан таниулах зорилгоор 25 фото мэдээ, 9 видео мэдээ, 27 контент, 3 постер тус тус хийж нийт 347743 хандалт авсан.
	132		XIII.7.. Цахим орчинд контент бүтээж орлого олох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцүүлэх асуудлыг 2023 онд багтаан шийдвэрлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгаж, Монголбанк (Б.Лхагвасүрэн)-нд зөвлөмж болгов.	Олон улсын стандарт, шаардлагыг хангасан төлбөрийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Монголбанк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банктай Apple компанийн "Apple Pay" үйлчилгээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нэвтрүүлсэн. "Apple Pay" үйлчилгээ нь IOS үйлдлийн систем бүхий Apple компанийн ухаалаг гар утас, ухаалаг цаг зэрэг бүтээгдэхүүнийг ашиглан хэрэглэгчдэд төлбөр хийх боломжийг олгодог. Энэхүү үйлчилгээ нэвтэрснээр үндэсний төлбөрийн "₮ карт"-ыг ашиглан олон улсад төлбөр тооцоо хийх нөхцөл бүрдсэн. Мөн манай улсын иргэдэд олон улсын төлбөр тооцооны шинэ гарцыг нээсэн чухал алхам болсон. Монгол Улсад ашиглагдаж буй 150 гаруй мянган ПОС төхөөрөмжүүдэд iPhone утсаа ашиглан төлбөр тооцоо хийх боломж бий болж байна. Дэлхийн хаанаас ч Монгол Улсын 1,600,000 гаруй IOS хэрэглэгчдэд iPhone, Apple Watch, Mac болон iPad гар утсаа ашиглан худалдан авалт хийх нөхцөл бүрдсэн. 2025 оны 02 дугаар 06-ны өдрийн байдлаар мастер карт ашиглан гүйлгээ хийсэн хэрэглэгчийн тоо 80,000 гаруй болсон байна.

92	133	2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2023-09-06 Дугаар 2023_36	XIII.7.4. Монгол Улсын талаар болон Монголоос олон улсын зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын сайд Ч.Номин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	БНХАУ-ын цахим худалдааны хаб Ханжоу хотноо 2023 оны 11 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд Төв Азийн Эдийн Засгийн Хамтын ажиллагаа (CAREC)-ны гишүүн 10 улсын 200 гаруй төлөөлөгчид чуулж, бүс нутгийн цахим худалдааны экосистем бүрдүүлж, цахим эдийн засгийн корридор байгуулахад шаардлагатай технологиудтай танилцаж, бодлогын шийдлүүдийг хэлэлцэв. Монгол Улсаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Жижиг дунд үйлдвэрийн газар, Говь ХК, АПУ ХХК, Lhamour, Airee зэрэг үйлвэрлэгч компаниуд, Shoppy, Intelmind, Fibo Cloud, Erxes, Go Lab зэрэг технологийн компаниуд төдийгүй тээвэр ложистикийн тэргүүлэгч компаниудын нэг Ти Ай Ложистик ХХК төлөөлөгчид оролцсон. Бүс нутгийн цахим худалдааны сүлжээнд холбогдож, хамтын ажиллагааны боломж эрэлхийлэх зорилго бүхий тус айчлалын хүрээнд төлөөлөгчид Ant International, Alibaba-ийн төвөөр зочилж, цахим худалдааны экосистемийг хөгжүүлэх сургалтад хамрагдаж, Ханжоу хил дамнасан цахим худалдааны тусгай бүс, Freshippo хиймэл оюун ухаанд суурилсан, бүрэн автоматжсан супермаркет, Alibaba-ийн олон улсын цахим худалдааны ухаалаг агуулах Cainiao зэрэг байгууллагуудаар зочилж, туршлага судлав. Мөн төлөөлөгчид цахим худалдааны экосистемд оролцогч 800 орчим компаниуд үзэсгэлэн гаргаж, 50,000 орчим зочид цугласан Global Digital Trade Expo-д оролцож, хамтын ажиллагааны санал солилцож байна. CAREC International Innovation Conference үеэр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Б.Тэмүүлэн Монгол Улсад цахим эдийн засаг хөгжүүлэх “Mining to Mind стратеги болон бүс нутгийн хамтын ажиллагааны боломж” танилцуулж, Gobi, Airee зэрэг байгууллагууд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулж оролцсон.
93	134	2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 37 дугаар тэмдэглэл 2023-09-13 Дугаар 2023_37	XV.9.. “Нээлттэй засаглалын түншлэл” олон улсын чуулга уулзалтын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсад цахим шилжилтийг эрчимжүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг судалж, холбогдох саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгав.	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан. Хуулийн 13 дугаар зүйлд тусгасан татварын болон татварын бус нийт 9 төрлийн дэмжлэгийг мэдээллийн технологийн аж ахуйн нэгжид үзүүлэх ажлыг бодитоор хэрэгжүүлэх зорилгоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийг байгуулсан.
94	135	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39	XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Тус яамнаас нийт 7 барилга байгууламжийн шинэ төсөл, арга хэмжээг улсын төсвөөр хэрэгжүүлэх саналыг Сангийн яаманд 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүнээс 5 төсөл, арга хэмжээ нь нэг маягийн зурагтай, 2 төсөл, арга хэмжээ зураг төсөл батлагдаагүй байна. /Газар эзэмших болон ашиглах зөвшөөрөлгүй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдээгүй./ Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас

95	136	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.2. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим системийг одоогийн цахим системд тулгуурлан хөгжүүлэх боломжийг судалж, танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгав	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын Үнэлгээний хороо байгуулах тухай А/186 дугаар тушаалаар төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт үнэлгээний системийн сайжруулалт зөвлөхөөс бусад үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас (www.tender.gov.mn)-д 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр нээлттэй байршуулж, 10 дугаар сарын 30-ны өдөр тендерийг нээсэн. Тус тендерт оролцогч байхгүй байсан тул тендер амжилтгүй болсон. Мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг шинэчлэн батлах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргаар ахлуулан ажиллаж байгаа бөгөөд дээрх журам шинэчлэн батлагдсны үндсэн дээр журмыг даган системд шинэчлэл хийгдэхээр байгаа болно.
96	137	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэл 2024-01-03 Дугаар 2024_1	7.1.6. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгүүдийн хэрэгжилтийн явц, тайланг хагас жил тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох сайд нарт	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагатай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ байхгүй болно. БНХАУ-ын Худалдааны яамнаас 2024 оны 03, 09, 11 сард зохион байгуулсан "Цахим худалдаа" сэдэвт сургалтад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 8 албан хаагч оролцсон ба тус сургалтад 2025 оны 4 дүгээр сард 6 албан хаагч тус тус хамрагдаж байна.
97	138	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэл 2024-03-06 Дугаар 2024_9	31.5. Үүнтэй холбогдуулан улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн болон болзошгүй гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын үед нэрвэгдэж болзошгүй иргэдэд мэдээлэл хүргэх, харилцаа холбооны тасралтгүй байдлыг хангах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл, харилцаа холбооны гадаад, дотоод сүлжээний дэд бүтцийг шийдвэрлэх, интернэт урсгалын хурдыг нэмэгдүүлэх, алслагдсан дүүрэг, сум, багийн сургуулийг нөөц эх үүсвэртэй болгох асуудлыг судалж, зохих арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт нарт даалгав.(Боловсролын салбарын нэгдсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдлын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав)	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл" /2025-2026 он/-ийн хүрээнд сумдын өндөр хурдны шилэн сүлжээний дамжуулах байгууламжийн хүчин чадлыг 10 дахин нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

	139	14.2.3.. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн хүрээнд гааль, хилийн байгууллагуудын хяналт удирдлагын нэгдсэн систем хөгжүүлэх ажлыг эрчимжүүлж, ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав."	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын (EAPF) Санхүүгийн салбарын бүс нутгийн хамтын ажиллагааны хэлтсийн Төрийн удирдлагын захирал Хатагтай Шиаокин Фаныг хүлээн авч уулзаж, "Цахим шилжилт" техникийн туслалцааны төслийг батлуулсанд талархал илэрхийлээд,төслийн хэрэгжилтийг ойрын хугацаанд эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа талаар танилцуулсан. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	140	14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав." (Үндэсний судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар)	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/88 дугаар тушаалаар төрийн байгууллагуудын захиалгаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, "sudalгаа.gov.mn" үндэсний судалгааны нэгдсэн системийг хөгжүүлж, 2023 оны 6 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг "И-Монгол академи" УТҮГ ханган ажиллаж байна. Судалгааны санд 1018 хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд 1914 судалгааг нээлттэй байршуулсан байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар тус системд 11569 хандалт хийгдсэн байна.

98	141	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27- ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12	14.14.3.. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем "И-Монголиа"-д нэгтгэх ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт, дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;(Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрсэн үр дүнгийн талаар)	Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хийсэн ажлын үр дүнг үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, "ХҮР"-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХҮР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2025 оныг дуустал чөлөөлсөн. 2025.04.01-ний өдрийн байдлаар 415 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд эрүүл мэндийн нийт 25 үйлчилгээг нэвтрүүлэн, ба 17 сая мэдэгдлийг хүргэж, 1.3 сая хандалтыг авсан. "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг нээлттэй байршуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан. 2025 онд ЭМЯ-тай хамтран эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр эхлүүлээд байна.
	142		14.14.5.. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцоход мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг "И-Монгол академи" УТҮГ (Б.Мягмарнаран), "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ (Т.Батбилэг)-т."	Ерөнхий сайдын 2023 оны 12 сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамжаар эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд систем хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт эрүүл мэндийн мэдээлэл солилцоонд шаардлагатай "И-Монгол" болон "ХҮР" системийн хөгжүүлэлтийг "И-Монгол академи" УТҮГ, эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн сан, түүний сервисийн хөгжүүлэлтийг "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ, эмийн бүртгэл, мэдээллийн системийн сервисийн хөгжүүлэлтийг "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ тус тус хариуцан ажиллаж бүрэн ашиглалтад оруулсан. "Эмийн жор", "Дүрс оношилгооны дүгнэлт", "Шинжилгээний хариу", "Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ", "Амбулаторийн карт", "Жирэмсний хяналтын хөтөч карт", "Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр"-ийн нийт 7 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай сервисийн гарын авлагыг боловсруулан, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох туршилтын ажлыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Гааль татвар санхүү мэдээллийн технологийн төв, Үндэсний дата төв, И-Монгол академи, Эрүүл мэндийн яам болон эмнэлгийн программ хангамж хөгжүүлэгч 7 аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулсан.

99	143	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад шилжих 2, шинээр хэрэгжих 9 нийт 11 төсөл, арга хэмжээнд 16,423.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг МУ-ын Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/140 дугаар тушаалаар тус тус Увс, Хөвсгөл аймаг, мөн ТЕЗ-ын харьяа шууд захирагч нарт эрх шилжүүлэн зохион байгуулж, гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант онд 316.6 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлсэн.
100	144	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17	20.6.2. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системийг шинэчлэн хөгжүүлэх ажлыг 2024 оны 6 дугаар сард багтаан хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалант нарт;	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас яамдын Төрийн нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, эхний ажлын хэсгийн хуралдаанаар хариуцан гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргаж, тус яамнаас холбогдох саналыг тусгасан. Мөн тус яамны худалдан авах ажиллагааны хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/186 дугаар “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар байгуулж, “үнэлгээний системийн сайжруулалт”-ын ажлын даалгаврыг боловсруулсан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэн батлагдсны дараа үнэлгээний системд хөгжүүлэлт хийх боломжтой байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	145		20.2. Үүнтэй холбогдуулан хууль тогтоомжийн төслийг боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгов.” (Нийслэл хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах хүрээнд хотын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.)	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас яамдын Төрийн нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, эхний ажлын хэсгийн хуралдаанаар хариуцан гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргаж, тус яамнаас холбогдох саналыг тусгасан. Мөн тус яамны худалдан авах ажиллагааны хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/186 дугаар “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар байгуулж, “үнэлгээний системийн сайжруулалт”-ын ажлын даалгаврыг боловсруулсан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэн батлагдсны дараа үнэлгээний системд хөгжүүлэлт хийх боломжтой байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас

	146	Дугаар 2024_15	20.11.2. Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлж, холбогдох сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;	Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн 6,090 хуудас мэдээллийн архивын материалыг нийт мэдээллийг машинд уншигдах хэлбэрээр бэлдэж 2023 оны 01/2240 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт, хэрэгжилтийг УИХ-д танилцуулахаар 2024 оны 01/858 дугаар албан бичгээр Ерөнхий сайдын Ажлын албанд, мөн 2024 онд 01/1142 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, ""Шилэн индекс""-ийг үнэлгээг хянан баталгаажуулах, холбогдох сургалтыг зохион байгуулах чиглэлийг 2024 оны 01/1147 дугаар албан бичгээр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт, системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 01/817 дугаар албан бичгийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар мэдээлэл хариуцагч 3431 байгууллагын 3694 албан хаагчид хандах эрхийг үүсгэн өгч, 6 удаагийн сургалтад хамруулсан.
	147		20.11.3. Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээс мэдээлэл хайх, авах үйлдлийг хөнгөвчлөх зорилгоор хиймэл оюуны хувилбарыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд	АМТ зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны сүүлийн үеийн (GPT) технологийг сургаж, ашиглалтад оруулсан.
	148		20.11.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх үйл ажиллагааг “Шилэн индекс”-тэй уялдуулан зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт.”	Мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн байгууллагын нээлттэй мэдээллийн үнэлгээг тухай бүр шинэчлэх, илгээх нөхцөлийг бүрдүүлэхээр Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан 68 нээлттэй мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж "Шилэн Индекс"-ийг тухай бүр нийтэлж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй 67 төрлийн мэдээллийг үнэлж "Шилэн индекс"-ийг зарласан. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 571 мэдээлэл хариуцагч байгууллага тайлан илгээж, 513 байгууллага үнэлэгдээд байна.
101	149	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1	20.4.. Гадаад улсаас ирж буй иргэдийг хилээр нэвтрүүлэх үйлчилгээг технологийн дэвшлийг ашиглан шуурхай, нэг цэгийн үйл ажиллагаанд шилжүүлэх асуудлыг судлан танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт тус тус даалгав.	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д улсын хилээр нэвтэрсэн иргэний лавлагааг олгож байна. Тус лавлагаа нь визний материал бүрдүүлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгал, татвар, банк санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, орон сууцны корпораци, орон сууц, нийтийн аж ахуйн контор, гэр бүл цуцлуулах, цэрэг татлагатай холбоотой нийслэл, аймаг, дүүргүүдийн Цэргийн штабт гарган өгөх зэрэг шаардлагад нийцэж байна. https://e-mongolia.mn/service/ulsyn-khileer-nevtersen-irgenii-lavlagaa

102	150	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1	18.17.2.. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан “Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу тус яамнаас “Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэсэн тэмдэглэл гарсны дагуу тус яамнаас 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний ажлыг зарлан Оюуны-инновац НҮТББ-тай Ү/06 дугаартай гэрээ байгуулсан. Грээт ажлын хүрээнд олон нийтийн радио телевизийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, контентын чанар, агуулга, хүртээмжийг сайжруулах болон үйлчилгээний хөлсийг оновчтой тогтоох санал, зөвлөмж бүхий тайланг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авсан. Хавсралт : 1 файл
	151		19.3.2.. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан “Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу тус яамнаас “Радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэсэн тэмдэглэл гарсны дагуу тус яамнаас 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний ажлыг зарлан Оюуны-инновац НҮТББ-тай Ү/06 дугаартай гэрээ байгуулсан. Грээт ажлын хүрээнд олон нийтийн радио телевизийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, контентын чанар, агуулга, хүртээмжийг сайжруулах болон үйлчилгээний хөлсийг оновчтой тогтоох санал, зөвлөмж бүхий тайланг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авсан. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас

103	152	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1	22.2.4.. Эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэлэлцээний үйл ажиллагаанд зохих дэмжлэгийг үзүүлж, Хэлэлцээний багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа яам, агентлагийн албан хаагчдын идэвх, оролцоог хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав	Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Гадаад харилцааны яамнаас 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан Үйлчилгээний бүлгийн ажлын хэсгийн уулзалтад оролцож, БНСУ-ын Сөүл хотноо 2023 оны 12 дугаар сард зохион байгуулсан эхний шатны хэлэлцээрийн талаар санал солилцов. Түүнчлэн 2024 оны 05 дугаар сарын сүүлээр Улаанбаатар хотноо зохион байгуулах хэлэлцээрийн бэлтгэл ажилд шаардлагатай мэдээлэл, саналыг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран боловсруулсан. 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан Монгол Улс, БНСУ хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн “Үйлчилгээний худалдаа (Цахилгаан холбооны үйлчилгээ)”-ний хоёрдугаар шатны хэлэлцээрт хэлтсийн дарга Д.Батбаяр, ахлах шинжээч Б.Эрдэнэ нар оролцож, Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас ирүүлсэн хэлэлцээрийн төсөлд санал өгсөн. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны хэлэлцээрт Харилцаа холбоо, Шуудан, Өргөн нэвтрүүлгийн салбарт тусгах саналыг боловсруулан баталгаажуулж, 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр bujinlkhamb.e@med.gov.mn цахим шуудангаар ЭЗХЯ-нд хүргүүлсэн.
	153		4.2.1.. Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай, зохих шаардлагыг ханган боловсруулж, “Засгийн газрын хуралдааны журам”-д заасан журмын дагуу санал авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хянуулсны үндсэн дээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав	Тус яамнаас цахим хөгжил, иноовац, харилцаа холбооны чиглэлээр 2025 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны 01/163 дугаартай албан бичгээр хүргүүлж, хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай, зохих шаардлагыг ханган боловсруулж хүргүүлж байна. Хавсралт : 1 файл

104	154	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэл 2024-07-17 Дугаар 2024_23	4.2.2.. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав: 2.1.яамны зохион байгуулалтын бүтцээ Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээ, яамны стратегийн тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгоо хангахад чиглүүлэн оновчтой тодорхойлж, яамдын бүтцийн нэгжийн ерөнхий загварт нийцүүлэн боловсруулж, 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; 2.2.орон тоо нэмэхгүй байх зарчим баримтлах; 2.3.хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах, төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах шийдвэр гаргахгүй байх; 2.4.яамны зохион байгуулалтын нэгжийн нэрийг Засгийн газрын агентлагийн нэртэй давхардахгүй байхаар тогтоож, чиг үүргийн давхардал үүсгэхгүй байх." гэжээ	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын тогтоол батлагдсан.
	155		4.4.1.. ТДараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав: 1.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд Монгол Улсын нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгаж, Засгийн газрын бүрэлдэхүүн дэх улс төрийн намуудын хамтран ажиллах эвслийн гэрээний зарчимд нийцүүлэн боловсруулах; 1.2.Засгийн газрын эхний 100 хоногт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны чиглэлээр Засгийн газрын эхний 100 хоногт хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/12 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны 100 хоногт хийж хэрэгжүүлсэн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 03/891 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/37 дугаартай албан бичгээр 2025 оны эхний 100 хоногт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хавсралт : 2 файл
	156		12.5.2.. Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, цогц арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нар	Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, цогц арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхэд хэрхэн хамтран ажиллах талаар 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/74 дүгээр албан бичгийг Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн. Энэ хүрээнд цахим шилжилттэй холбоотой хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлсэн. /И-Монгол цахим системд эрүүл мэндийн үйлчилгээний цэс, эмийн жор гэх мэт/

105	157	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл 2024-07-24 Дугаар 2024_24	12.5.3.. Эрүүл мэндийн байгууллагуудад кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийлгэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд, дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нар	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Халдлага зөрчилд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд тус яам, Зөвлөлийн Ажлын алба, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв, Нийтийн төв хамтран 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс өдөр Эрүүл мэндийн яаманд ажиллаж, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг шалгасан. Уг шалгалтын дүнгээс үзэхэд албан хэрэглээнд албан ёсны эрхгүй программ хангамж ашиглаж байсан, байгууллагын сүлжээнд холбогдож буй албан хаагчдад кибер аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийдэггүй, мөн хэрэглэгчийн удирдлагын системийн үйлдлийн бүртгэлийг хөтөлдөггүй зэрэг эрсдэл илэрсэн. 2025 онд Эрүүл мэндийн яамтай хамтран эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ хийх ажлыг Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр эхлүүлээд байна.
	158		12.6.2.. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаварт туссан төсөл, арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Хамтарсан Засгийн газрын гэрээтэй уялдуулан, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав	Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөлд шаардлагатай санхүүжилтийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны төсвийн захирагчийн 2024 оны төсвийн тодотголд тусгуулах нэмэлт саналыг 2024 оны 08 дугаар сарын 06-ны 01/75 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
	159		1.2.. Яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчдыг хууль бусаар халж, чөлөөлөхгүй байхыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт даалгав	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 06 дугаар тогтоол, “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны, стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” 44 дүгээр тогтоолыг үндэслэн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл, орон тоог Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/80 дугаар тушаалаар баталсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бүтцийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг чөлөөлж томилсон. Хууль бусаар чөлөөлсөн албан хаагч байхгүй болно.
106	160	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр	31.9.6. 1/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст иргэд, олон нийтийн саналыг авсны үндсэн дээр хөгжүүлэлт хийж, холбогдох төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг “И-Монгол академи” УТҮГ-т, техник хангамжийн бэлэн байдлыг хангаж, найдвартай үйл ажиллагааг хариуцаж ажиллахыг “Үндэсний дата төв” УТҮГ-т	Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг нэг цонхоор, нэг стандартаар иргэдэд хялбар, ойлгомжтой хүргэхээр төрийн үйлчилгээний нэгдсэн веб gov.mn-ийг И Монгол академи УТҮГ хөгжүүлж, холбогдох сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 17-23-ны өдөр нийт 12 яамны 12 албан хаагч, нийслэлийн 1 албан хаагч, 21 аймгийн 40 албан хаагч хамруулсан. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 1416 төрийн байгууллагад хандах эрхийг олгож мэдээлэл байршуулан ажиллаж байна. Цаашид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2-т заасан 67 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээллэх shilen.gov.mn системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх нэмэлт хөгжүүлэлт хийгдэж байна.

107	161	тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31	31.9.6. 3/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудсыг 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, энэ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нарт	Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг нэг цонхоор, нэг стандартаар иргэдэд хялбар, ойлгомжтой хүргэхээр төрийн үйлчилгээний нэгдсэн веб gov.mn-ийг И Монгол академи УТҮГ хөгжүүлж, холбогдох сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 17-23-ны өдөр нийт 12 яамны 12 албан хаагч, нийслэлийн 1 албан хаагч, 21 аймгийн 40 албан хаагч хамруулсан. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 1416 төрийн байгууллагад хандах эрхийг олгож мэдээлэл байршуулан ажиллаж байна. Цаашид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2-т заасан 67 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээллэх shilen.gov.mn системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх нэмэлт хөгжүүлэлт хийгдэж байна.
	162	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд 2024-10-02 Дугаар 2024_35	14.2.1.. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаатай уялдуулж, санал, хүсэлт хүлээн авах дуудлагын утсыг нэгтгэх техник, технологийн боломжийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нартай хамтран хэрэгжүүлж, үр дүнг 14 хоногт багтаан танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/42 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, үр дүнг Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар 41 дүгээр тэмдэглэл батлагдсан. Иргэд, олон нийттэй харилцах төвд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс E-Mongolia notification системээр дамжуулж, иргэнд мэдэгдэл хүргэж эхэлсэн. "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д 11-11 төвийн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл болон нислэлийн хэмжээнд 101, 102, 103, 105 дуудлагын утасны нийт дуудлагын мэдээллийг дашбоард хэлбэрээр харах боломжийг бүрдүүлээд байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	163		14.3.2.. “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн бэлтгэл ажлыг хангах, төслийн хэрэгжилтийг хариуцан ажиллах чиг үүргийг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд үүрэг болгов	Бүгд найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компани ЦХИХХЯ хооронд байгуулах “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” арилжааны гэрээг эцэслэхээр ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	164		14.3.3.. “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн оператор компаниар “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийг ажиллуулах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцааны холбооны сайд Ц.Баатархүү нарт даалгав.” гэжээ	“Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн оператор компаниар “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийг ажиллуулах асуудлыг судалж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас

108	165	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэл 2024-10-30 Дугаар 2024_38	38.17.9.5. Боловсрол, шинжлэх ухаан, мэдээллийн технологи: •Хоёр улсын Засгийн газрын тэтгэлгээр Монгол, Казахстаны оюутан залуусыг их, дээд сургуульд харилцан сургах, бусад тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, •Шинжлэх ухаан, стратеги судалгааны шилдэг туршлагыг харилцан солилцох, хамтран судалгаа, шинжилгээний ажил хийх, •Цахим хөгжил, мэдээллийн технологи, цахим засаглал, сансрын технологи, харилцаа холбооны салбарын чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд.	Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүгд Найрамдах Казахстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн яам хооронд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах санамж бичгийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан. Энэхүү хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Талууд үндэсний хэмжээний тулгамдсан асуудлуудыг харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглан тодорхойлох, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх чиглэлээр туршлага хуваалцах; Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын жижиг, дунд үйлдвэрлэл, инновац, гарааны бизнес эрхлэлтийг дэмжсэн хөрөнгө оруулалт татах чиглэлээр хамтран ажиллах;Шинэ болон нэн шинэ технологи, шинжлэх ухаан, өндөр технологийн чиглэлээр мэдээллийн технологийн парк, академи болон бусад байгууллагуудын сайн туршлагыг хуваалцах, хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжилтнүүдийг бэлтгэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хамтран ажиллах, Хиймэл оюун, их өгөгдлийн шинжилгээ, өндөр хүчин чадалтай тооцоолол, блокчейн, зүйлсийн интернэт зэрэг нэн шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах, хиймэл оюун дээр түшиглэсэн шийдлийг улсын байгууллагуудад нийлүүлдэг платформын талаар туршлага судлах талаар хамтран ажиллахаар зорьж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	166		39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3.нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4.хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.5.хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6.захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7.энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хуулиар тусгайлан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон 41 заалтын хүрээнд нийтээр заавал дагаж мөрдүүлэх, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй 31 шийдвэр батлагдахаас захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй хүчин төгөлдөр үйлчиж байгаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын дангаар баталсан 20, бусад захиргааны байгууллагатай хамтран баталсан 5, нийт 25 шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт хүргүүлсэн.

167	39.29.11.4. Дараах асуудлыг судалж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. (Үүнд:4.1.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа болон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн шийдвэрүүдийг онол, арга зүйн хувьд нягтлан судалж, дүн шинжилгээ хийн Засгийн газрын 2023 оны 48 дугаар тэмдэглэлийн 4 дэх заалтаар өгөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг 2 дахин багасгах үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх; 4.2.хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний актаар зайлшгүй зохицуулах хэм хэмжээг тусгахдаа түүний агуулга, тавигдах шаардлагыг тодорхой зааж, хуулийн төсөлд заасан захиргааны хэм хэмжээний актын төслийг хамтад нь боловсруулж хэлэлцүүлэн, санал авч байх; 4.3.хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр батлан гаргахгүй байх. -ыг заалт бүрээр гаргаж тайлагнах)	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар сайдын эрхлэх асуудлын хүрээний хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг яам болон Харилцаа холбооны зохицуулах хорооны төлөөллийг оролцуулан байгуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Мэдээллийн технологийн үйлвэрлэлийг дэмжих тухай хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрхийг Засгийн газарт олгосон 34, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад олгосон 41, Харилцаа холбооны зохицуулах хороонд олгосон 23, нийт 98 заалт, түүний дагуу баталсан сайд баталсан 51, Харилцаа холбооны зохицуулах хороо баталсан 46 хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор “Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл”, холбогдох хуулийн төслийг боловсруулсан.
168	39.29.12.1. Кибер аюулгүй байдлыг хангахад зориулсан зардлыг төсвийн эдийн засгийн ангилалд тусгах асуудлыг судалж, шийдвэрлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Сангийн сайд Б.Жавхлан нарт	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулахаар Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т кибер аюулгүй байдлын зардлын ангиллыг шинээр нэмж тусгуулах саналыг Сангийн сайдад 2024 оны 01/724 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Зардлын эдийн засгийн ангилалд кибер аюулгүй байдлын зардлын ангиллыг шинээр нэмж тусгаснаар кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах дэд бүтцийг сайжруулах боломж бүрдэнэ. Мөн Инновац, цахим бодлогын байнгын хороонд 2025 оны 01 сарын 14-ний өдөр танилцуулж, УИХ-ын байнгын хорооны 2 дугаар тогтоолоор Улсын нэгдсэн төсвийн ангилалд Мэдээллийн технологийн арга хэмжээ, кибер аюулгүй байдлын зардлын ангиллыг шинээр нэмж, тус бүрд программ хангамж, техник хангамжаар ялгахыг Засгийн газарт чиглэл болгосон. Улмаар "Зардлын эдийн засгийн ангилал"-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/518 дугаартай албан бичгээр хүргүүлээд байна.

109	169	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.12.2. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд;	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, жагсаалтыг шинэчлэх суурь судалгааны асуулгыг 3 бүлэг 93 асуулттайгаар боловсруулсан. Судалгааны асуулга бүхий вэб хуудсыг хөгжүүлж, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудад 2024 оны 03/710 дугаартай албан бичгийг хүргүүлж, судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад байгаа байгууллагуудын 77.5 хувь нь уг жагсаалтад багтах шаардлагатай гэж үзэж байгаа бол 22.5 хувь энэ жагсаалтаас хасуулах хүсэлтэй байсан. "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоол болон Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтын төслийг боловсруулж байна.
	170		39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Тус яам нь Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор баталсан "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт"-д багтаагүй. Байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хариуцах албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/12 дугаар тушаалын 29 дүгээр хавсралтаар баталсан. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс
	171		39.29.11.1.2. эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгон, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (1.1Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв)	Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас гарсан дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгоход ач холбогдолгүй цаг хугацаа шаардсан, шат дамжлага үүсгэсэн баримт бичгийг хүчингүй болгох хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/81 дүгээр тушаалаар баталсан "Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага"-ыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах хүсэлтийг ХЗДХЯаманд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/353 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалаар баталсан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ыг сайдаас хүчингүй болгох шаардлагагүй гэж үзэн хэвээр үлдээсэн.

	172		39.29.11.1.3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа, түүнчлэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагаж мөрдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгосон заалтын судалгааг гаргаж, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;(1.4.цаашид нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, санд хөдөлгөөн хийлгэх ажлыг хэвшүүлэх; 1.5.Шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллах; 1.6.Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллах;))	Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн дагуу салбарт мөрдөж байгаа зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа салбарын сайдаас баталсан 2, Харилцаа холбооны Зохицуулах хорооноос баталсан 44 актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж салбарын сайдаас баталсан 1 актыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгож, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулаад байна. Харилцаа холбооны Зохицуулах хорооноос баталсан 27 актыг хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгогдоогүй, хуулиар олгосон эрхийг хэтрүүлсэн, Зөвшөөрлийн тухай хуулийг зөрчсөн, бизнес эрхлэгчдэд дарамт, тээг болсон шат дамжлага үүсгэсэн шинжтэй гэж үзэж зөрчилтэй актуудыг хуульд нийцүүлж, хүчингүй болгох арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлсэн. Тус хорооноос 6 актыг бүхэлд нь, 8 актын 82 заалтыг тус тус хүчингүй болгосон талаар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/289 дугаартай албан бичгээр мэдэгдээд байна.
	173		39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	"3.2.Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаас гарсан дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгоход ач холбогдолгүй цаг хугацаа шаардсан, шат дамжлага үүсгэсэн баримт бичгийг хүчингүй болгох хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасуулахаар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/353 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, улсын нэгдсэн бүртгэлийн сангаас хассан тухай албан бичгийг Хууль зүй, Дотоод хэргийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн1/1414 дугаар албан бичгээр ирүүлсэн. 3.3.Байхгүй 3.4.Байхгүй 3.5.Байхгүй 3.6.Байхгүй 3.7.Зохих журмын дагуу хүргүүлсэн."
110	174	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43	43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан XIX.1.4 Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун сум/, XIX.1.1 Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ шилжих Багц-5 төслийн үлдэгдэл санхүүжилт болох 165.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан. Төслийн улсын комисс ажиллаж дуусмагц санхүүжилтыг олгоно. Мөн зүгшрүүлэх, тохируулах чанарын баталгаат хугацаа дууссан төслийн чанарын баталгааг тухай бүрд нь чөлөөлж байна.

111	175	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл 2025-01-14 Дугаар 2025_03	3.12.3.1. Шуурхай штабаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг яаралтай зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгав;(Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт, шуурхай удирдлагаар хангах Шуурхай штабын анхдугаар хуралдааны талаар)	Монгол Улсын Засгийн газраас “2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын зохицуулалт бүхий асуудалд тухай бүр санал өгсөн. Тухайлбал, тус яамнаас "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/719 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.
112	176	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.1.11. Агаар, орчны бохирдлын талаар холбогдох төрийн байгууллагуудын тоон болон чанарын үзүүлэлт бүхий мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан, нэгдсэн дашбоард үүсгэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, холбогдох мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавьж, тухай бүр шинэчилж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд	Цаг уур, орчны шинжилгээний газрын цахим хуудас (agaag.mn)-аас Улаанбаатар хотын 21 байршлын агаарын чанарын үзүүлэлт болон цаг агаарын мэдээллийг татан Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д харуулж байна. Цаашид мэдэгдэл хүргэх системд сайжруулалт хийж агаарын чанарын индекс зөвшөөрөгдөх түвшнээс давах үед тухай бүсийн хэрэглэгчид руу мэдэгдэл илгээх ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.
	177		44.22.3.7. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс аж ахуйн нэгжтэй харилцах бүхий л үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-Mongolia-д нэгтгэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт.”	"Бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн этгээдэд зориулсан платформ И-Бизнес (e-business)-ийг 2023 оны 07 дугаар сард 800 үйлчилгээтэйгээр хэрэглээнд нэвтрүүлсэн. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдтэй холбоотой нийт 832 үйлчилгээг нэгтгэж, иргэд 277,032 удаа үйлчилгээ авсан байна.
	178		44.22.6.1. Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэн тохиролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох талын оролцоог хангуулан шинэчлэн байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт, Ажлын хэсэгт хариуцсан чиг үүргийн дагуу удирдах албан тушаалтныг оруулан идэвх, оролцоог хангаж ажиллуулах, шаардлагатай мэдээллийг тухай бүр хүргүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгав	Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд байгуулах Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй танилцаад, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/730 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

	179		44.22.8.1. Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (shilenkhyanalт.gov.mn)-ийн шинэчлэлийг хийж, системийн хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд;	Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн сан http://shilenkhyanalт.gov.mn/ цахим сангийн сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаа болон программ хангамж, системийн зохицуулалт, нэвтрэх эрх олгох асуудал болон хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг ажлыг өдөр тутамдаа зохион байгуулан ажиллаж байна. Тус системд 11 яам, төрийн захиргааны 2 байгууллага, орон нутгийн 28 хяналтын чиглэлийн нийт 1197 улсын (ахлах) байцаагч бүртгэгдсэн бөгөөд хяналт шалгалтын мэдээллийг бүртгэж байна. 2025 оны батлагдсан төлөвлөгөөт шалгалтын жагсаалтад 7952 объект бүртгэгдсэн.
113	180	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2025-01-22 Дугаар 2025_05	5.24.10.1. Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулах төлөвлөгөөний талаар)	Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд цахим технологийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох, зүүн бүс нутагт ажиллаж байгаа салбарын мэргэжилтэн, албан хаагчдын санал санаачилгыг дэмжих, санал хүсэлтийг бодлого, арга хэмжээнд тусган ажиллах зорилготойгоор харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нэгдсэн чуулга уулзалтыг Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Тус чуулганы үеэр: 1.Мэдээллийн технологийн төрөлжсөн ХАБ-ыг Хэнтий аймагт байгуулах санамж бичгийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэдээлэл технологийн үндэсний парк хооронд байгуулсан. Санамж бичигт мэдээллийн технологи ба дэвшилтэт технологи, инновацын технологийн төрөлжсөн хабыг байгуулах, мэдээллийн технологийн төрөлжсөн хабыг түшиглэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин бүх төрлийн хөрөнгө оруулалт хийх, арга хэмжээг зохион байгуулах, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талаар тусгасан. Мөн Хэнтий аймагт Зүүн бүсийн логиستيкийн төв байгуулах санамж бичгийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Монгол шуудан ХК хооронд байгуулсан. Санамж бичигт Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газраас тус төвийг байгуулах газар, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, Монгол шуудан ХК-иас уг төвийг бүтээн байгуулж, зүүн бүсийн иргэдийн тээвэр логиستيкийн хэрэгцээг хангах, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний бодит өртгийг бууруулах боломжийг бүрдүүлэх чиглэлд хамтран ажиллахаар болсон. 2.Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн мэдээллийн технологийн болон захиргааны албан хаагчид мэдээллийн аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. 3.Зүүн бүсийн бүх сум төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор бүсийн Хэнтий аймгийн 17 сум, Сүхбаатар аймгийн 13 сум, Дорнод аймгийн 14 сум, нийт 45 суманд Төрийн үйлчилгээний киоск машиныг гардуулсан. Хавсралт : 1 файл
	181		5.24.1.1. Шуурхай штабын хуралдааны үеэр Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээр тогтсон асуудалд холбогдох саналаа яаралтай горимоор өгч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	Шуурхай штабын хуралдааны үеэр Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээр тогтсон асуудалд холбогдох саналыг тухай бүр хүргүүлж байна.

114	182	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06	6.26.5.2.2. “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ХИЙМЭЛ ОЮУН УХААН (AI), өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд холбогдох ажлыг шат дараатай хийж байна. Сайдын 2025.02.27-ний өдрийн А/42 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Хиймэл оюуны стратеги боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж, тус ажлын хүрээнд ЭЗХЯ болон холбогдох бусад яамд, байгууллагуудыг оролцуулсан хэлэлцүүлгийг тухай бүрт зохион байгуулж байна. Мөн хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх стратегийг тодорхойлох хүрээнд 2025 оны 3 дугаар сард салбарын их, дээд сургуулиудын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, стратегит оруулах ажлыг тодорхойлсон. 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратегийн төслийг боловсруулан Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлуулсан.
	183		7.26.1.1. Шуурхай штабын хуралдаан дээр Ерөнхий сайдаас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг тухай бүр ERP системд тусгаж ажиллахыг Засгийн газрын нийт гишүүдэд;	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем /ERP/-д дээд газраас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	184		7.26.2.2.1. хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах замаар хугацааг багасгаж, ажлын 3 өдөрт багтаан ашгийн төлөө хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх боломжийг судалж, холбогдох зохицуулалтыг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; (2. Аж ахуйн үйл ажиллагааг эхлүүлэх үе шатанд тулгардаг хүндрэл, шат дамжлага, хугацааг багасгах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав:)	Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу И-Бизнес системийг УБЕГ-ын хуулийн этгээдийн “ERS” системтэй мэдээлэл солилцох холболтыг хийх, хуулийн этгээдийн нэрийн давхардлыг хиймэл оюуны тусламжтай шалгах боломжийг бүрдүүлэхээр холбогдох чиглэлийг 2025 он 01/729 албан бичгээр И Монгол академи УТҮГ-т хүргүүлээд байна.

115	185	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-05 Дугаар 2025_07	7.26.2.2.4. харьяа салбарын хүрээнд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг цахимжуулж, цахимаар шийдвэр гаргах хугацааг тогтоож, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (www.license.mn)-д 2025 оны 2 дугаар улиралд багтаан оруулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ (Т.Батбилэг), "И-Монгол академи" УТҮГ (Б.Мягмарнаран)-т. (2.Аж ахуйн үйл ажиллагааг эхлүүлэх үе шатанд тулгардаг хүндрэл, шат дамжлага, хугацааг багасгах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав)	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд нийт 251 тусгай зөвшөөрлөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 43, эрх бүхий байгууллага өөрийн системээр 116, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож байна.
	186		7.26.2.3.3.4. Энэ тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт даалгав.	Цахим хөгжил,инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг нэгтгэн сар бүрийн 10-ны өдрийн дотор Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn-д оруулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлэгдэн 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1221 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.
116	187	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-02-19 Дугаар 2025_09	9.24.2.2. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн олгосон ногдол ашгийг иргэд хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлэх болон төрөлжсөн сан хооронд шилжүүлж хуримтлуулах, арвижуулах нөхцөл боломжийг судлан үзэж, холбогдох зохицуулалтыг бий болгох чиглэлээр зохих шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, "И-Монгол академи" УТҮГ-ын захирал (Б.Мягмарнаран), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д;	Үндэсний баялагийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг ХҮР сервисээр авч харуулах талаар холбогдох байгууллагатай И Монгол академиас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр уулзалт хийж, шийдэл боловсруулсан. Ойрын хугацаанд мэдээллийг оруулахаар ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	188		9.24.2.3. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг виртуал карт, хадгаламжийн дэвтэр болон бусад хэлбэрээр иргэдэд хүргэх асуудлыг судалж, хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, "И-Монгол академи" УТҮГ-ын захирал (Б.Мягмарнаран), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (С.Наранцогт)-д;	Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмын 8.7.1 болон 8.7.2 дахь заалтын хүрээнд хуримтлалын нэрийн дансны мэдээлэл харуулах хөгжүүлэлтийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д хийж 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр бодит орчинд нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн профайл цэсэнд Чингис хаан үндэсний баялагийн сан цэс байршиж байна.

117	189	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-26 Дугаар 2025_10	10.19.6.1. Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны ногдол ашгийг хуваарилахтай холбогдуулан “И-Монголиа” цахим системээр дамжуулан санал асуулгад оролцож, хуримтлуулах болон хандивлах санал өгсөн иргэдийн саналыг дахин баталгаажуулах арга хэмжээ авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал (Б.Мягмарнаран) нарт;(19.6.Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцаанд хуваарилах 2024 оны ногдол ашгийн талаар)	Үндэсний баялагийн сангийн Хуримтлалын сан дахь иргэдийн нэрийн дансны орлогын мэдээллийг ХУР сервисээр авч харуулах талаар холбогдох байгууллагатай И Монгол академиас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр уулзалт хийж, шийдэл боловсруулсан. Ойрын хугацаанд мэдээллийг оруулахаар ажиллаж байна.
	190		10.19.4.1. Тогтоол, шийдвэр батлах эрх зүйн үндэслэлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний дугаар, өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой зааж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:(19.4.Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн талаар)	Цахим хөгжил,инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг нэгтгэн сар бүрийн 10-ны өдрийн дотор Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn -д оруулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлэгдэн 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1221 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Хавсралт : 1 файл
	191		10.19.4.2. Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цахим хөгжил,инновац, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг нэгтгэн сар бүрийн 10-ны өдрийн дотор Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем www.unelgee.gov.mn -д оруулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтад авсан 358 зүйл, заалтын хэрэгжилтийг дунджаар 89,19%-тай үнэлэгдэн 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1221 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.
118	192	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-03-12 Дугаар 2025_12	12.3.2. Уг хэлэлцээнд эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд оролцох яам, агентлагийн албан хаагчдыг бүрэн хариуцлагатай оролцох байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав	Уг хэлэлцээрийн талаар Эдийн засаг, хөгжлийн яаманд байгуулагдсан ажлын хэсэгт тус яамнаас албан хаагч ороогүй бөгөөд эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай үед бүрэн хариуцлагатай оролцох байдлыг хангаж ажиллахад бэлэн байна.
ЗГ-ын албан даалгавар				

119	193	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ төрийн мэдээлэл солилцооны ХУР системээс иргэний мэдээллийг хурууны хээгээр баталгаажуулах сервисийг ашиглах талаарх зөвлөмжийг Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 06/2052 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. “Гадаад худалдааны цахим нэг цонх” системд дүгнэлт, зөвлөмж өгөх асуудлаар Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкттай уулзалт зохион байгуулж, шаардлагатай зөвлөгөө мэдээллийг 10 дугаар сарын 02-ны өдөр өгсөн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхлэсэнээс хойш нийт 51 системд дүгнэлт зөвлөмж өгсөн. Үүнээс 2024 оны 11 сараас ISR.gov.mn системийг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн бөгөөд систем ашиглалтад өгснөөс хойш 3 системд дүгнэлт зөвлөмж өгсөн байна.
	194		6. Цахим шилжилтийг дэмжих, дижитал эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт үүрэг болгосугай.	"И-Монгол" Улсын төсөвт үйлдвэрийн газрын бүтцэд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлийн сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулах чиг үүрэгтэй "Цахим ур чадварын газар"-ыг байгуулсан. Тус нэгжээр дамжуулан 2022 оны 03 дугаар сараас 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл хугацаанд 126 удаагийн нийт 20.441 иргэн хамрагдсан сургалтыг хийгээд байна. Тодруулбал: Өндөр настан, ахлах сургуулийн сурагчид, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Оюутан, залуус, төрийн албан хаагч, алслагдсан дүүргийн иргэд гэсэн зорилтод бүлгийн хүрээнд Цахим иргэн, Мэдээлэл өгөгдөлтэй ажиллах ур чадвар, Мэдээллийн аюулгүй байдал, Харилцаа холбоо, Асуудал шийдвэрлэх ур чадвар, Программ хангамжийн ур чадвар, Цахим засаглал, Цахим хөгжлийн багц хуулийн танилцуулга, Тоон гарын үсэг, түүний хэрэглээ гэсэн агуулгаар сургалтыг орсон. Иргэдийн мэдээллийн технологийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Тоон бичиг үсэгтэн" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны А/19 дүгээр тушаалаар Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилласан. Тус ажлын хэсгээс "Цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 6 дэд зорилттойгоор боловсруулж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны улмаар салбарын үндэсний хөтөлбөрийг цаашид батлуулах боломжгүй болсон тул уг хөтөлбөрийг арга хэмжээний төлөвлөгөө хэлбэрээр шинэчлэн боловсруулж Цахим хөгжил, харилцаа холбооны, Боловсрол, шинжлэх ухааны, Соёлын болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар 2022 оны 07 дугаар сарын 23-ны өдөр батлуулсан.

120	195	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	1. Цахим шилжилт, төрийн бүтээмж, залуучуудын үзэл бодол, нийгмийн оролцоо, замын тэмдэглэгээ, гэр хорооллын хөгжил, цахим гэмт хэрэг зэрэг цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дараахь арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор авахыг Засгийн газрын дор дурдсан гишүүд, холбогдох албан тушаалтанд тус тус ДААЛГАСУГАЙ: 1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд: 1.1.Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим шуудангийн системийг ашиглалтад оруулж, төрийн албан хаагчдад нэвтрүүлэх; 1.2.Төрийн байгууллагуудын нэгдсэн программ хангамжаар хангах, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах нэгдсэн систем бий болгох судалгаа хийж, саналаа танилцуулах;	2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар нийт 955 домэйн /байгууллагын/ бүхий 60,763 хэрэглэгчийн 12.544 ТВ цахим шуудан үүсгэн ашиглаж байна.
	196		7. Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай бол Ажлын хэсэг байгуулж ажиллах, биелэлтийг Төрийн бүтээмжийн болон Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороодын хуралдааны тус тус хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний хороо (Орлогч дарга Л.Энх-Амгалан, Л.Халтар)-нд даалгасугай.	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжийн 1.3 болон 2.2 дахь заалтад ажилтан, албан хаагчдынхаа дунд "Нэг чиглэлээс нэг автомашинаар" (car pooling, car sharing) буюу машин хуваалцах үйлчилгээг нэвтрүүлж, санаачилгыг өрнүүлэн хэрэгжүүлэх талаар тусгаж, төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан.
121	197	Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай 2022-11-16 Дугаар 2022_16	1. Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт: 1.Гаалийн хяналтын талбай болон албан ажлын өрөөнүүдийг камержуулах арга хэмжээг бүрэн дуусгах; 2.Гаалийн байгууллагын үйлчилгээг цахимжуулж, хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах, барааг урьдчилан мэдүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах; 3.Гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох арга хэмжээг эрчимжүүлэх;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон ""И-Монгол академи"" УТҮГ-ын албан хаагчид 08 дугаар сарын 01-ний өдрөөс 04-ний өдөр хүртэл Дорноговь аймгийн Замын-Үүд суманд албан томилолтоор ажиллаж Хилийн боомт дахь хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны зураглал хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон, мөн Засаг даргын Тамгын газарт ажиллан цахим шилжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үндэслэн Замын Үүд суманд цахим шилжилт хийх төслийн баримт бичгийг, төсвийн төсөөллийн хамт боловсруулсан. Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 23/247 дугаар албан бичгээр "Хилийн боомтын мэдээллийн нэгдсэн систем"-д зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/2367 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

122	198	2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_01	5.5.□Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж нарт	Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн XXII.2.2 дугаарт ""Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах"", XXII.2.3 дугаарт ""Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах""-ыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус даалгасантай холбогдуулан ""shilen.gov.mn"" системийн 2.0 хувилбарын тусламжтай мэдээлэл хариуцагч байгууллага нээлттэй мэдээллээ оруулах, шинэчлэх, үнэн зөв, бүрэн, бүтэн байдлыг хариуцах боломжийг бүрдүүлээд байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй 68 төрлийн мэдээллийг үнэлж ""Шилэн индекс""-ийг зарласан. Нээлттэй мэдээллийн нэгдсэн системд 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 571 мэдээлэл хариуцагч байгууллага тайлан илгээж, 513 байгууллага үнэлэгдээд байна.
	199		6.8.. Хил дамнасан онлайн худалдааны боломжийг бий болгох, олон улсын төлбөр тооцооны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;	Олон улсын стандарт, шаардлагыг хангасан төлбөрийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Монголбанк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкттай Apple компанийн "Apple Pay" үйлчилгээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нэвтрүүлсэн. "Apple Pay" үйлчилгээ нь IOS үйлдлийн систем бүхий Apple компанийн ухаалаг гар утас, ухаалаг цаг зэрэг бүтээгдэхүүнийг ашиглан хэрэглэгчдэд төлбөр хийх боломжийг олгодог. Энэхүү үйлчилгээ нэвтэрснээр үндэсний төлбөрийн "₮ карт"-ыг ашиглан олон улсад төлбөр тооцоо хийх нөхцөл бүрдсэн. Мөн манай улсын иргэдэд олон улсын төлбөр тооцооны шинэ гарцыг нээсэн чухал алхам болсон. Монгол Улсад ашиглагдаж буй 150 гаруй мянган ПОС төхөөрөмжүүдэд iPhone утсаа ашиглан төлбөр тооцоо хийх боломж бий болсон. Дэлхийн хаанаас ч Монгол Улсын 1,600,000 гаруй IOS хэрэглэгчдэд iPhone, Apple Watch, Mac болон iPad гар утсаа ашиглан худалдан авалт хийх нөхцөл бүрдсэн. Мөн хил дамнасан онлайн худалдааг дэмжих зорилгоор БНХАУ-ын Taobao&TMall группын захирал Тони Чентэй хамтарсан уулзалт зохион байгуул, санал солилцсон.

	200	7.14. ЭЭрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, систем хооронд мэдээлэл солилцох боломжийг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	ЕС-ын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг 8 удаа хуралдан, үр дүнг ЗГ-ын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Ажлын хэсгийн гишүүдэд төлөвлөгөөг 02/170 дугаар албан бичгээр хүргүүлж, “Дэд ажлын хэсэг”-ийг А/04 дүгээр тушаалаар байгуулсан. Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, “ХУР”-д 24 шинэ сервисийг нэвтрүүлсэн. Хөгжүүлэлтийн 6 удаагийн туршилтыг хийж, 2024.04.03,17-ны өдөр 4 эмнэлэг, ЭМДЕГ, ЧДХХҮГ дээр очиж шалгасан. Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулан, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2024.12.01-ний өдөр хүртэл чөлөөлсөн. 2024.08.30-ны өдрийн байдлаар 346 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд “Эмийн жор”-ыг 2024.03.27-нд, 70 төрлийн 120 эмийг AR технологиор баяжуулж 2024.04.18-нд, оношилгоо, шинжилгээний хариу, дүгнэлт, жирэмсний хяналтын хөтөч карт, хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ, амбулаторийн картыг 2024.05.07-нд, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг 2024.05.31-нд хэрэглээнд нэвтрүүлсэн ба 9,953,206 мэдэгдлийг хүргэж, 529,804 хандалтыг авсан. “Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ”-ний судалгааг 325 байгууллагаас авч, үр дүнг 2024.04.08-ны өдөр танилцуулсан. ЭМТХ-ийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 rack, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг ҮДТ-өөс үзүүлж байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2024.04.08,09-нд 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/, сургалтыг 2024.04.16-нд анхан шатлалын байгууллагын 200 төлөөлөлд, 2024.05.04-24-нд 21 аймаг, нийслэлд зохион байгуулж эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан.
--	-----	--	---

	201	1.6. Их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан цахим шилжилтийн реформыг хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нарт;	Тус яамнаас Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Их өгөгдөл, хиймэл оюуны стратеги” анхдугаар чуулганыг Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан. Уг анхдугаар чуулганд төрийн байгууллага, бусад улсаас Монгол улсад суугаа элчин сайд, олон улсын байгууллага, аймаг орон нутгийн болон салбарын харьяа байгууллага, их дээд сургууль, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, арилжааны банк, финтекийн холбооны нийт 1077 төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал, бэлэн байдлын үнэлгээ, мөн хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон хиймэл оюуны стратегийн төслийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Мөн Цахим хөгжил инновац харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 27 ны өдрийн А/42 тушаалаар "Их өгөгдөл, хиймэл оюун стратеги хэлэлцүүлэх анхдугаар чуулга"-ны хэлэлцүүлэгт оролцсон олон улсын судлаачид, хувийн хэвшлийн төлөөлөл, мэргэжлийн холбоо, төрийн байгууллагуудаас гаргасан саналыг нэтгэн боловсруулж, их өгөгдөл хиймэл оюуны стратеги төлөвлөгөөний төсөл тусгах ажлын хэсэг байгуулагдсан, стратеги төлөвлөгөөний эхний төслийг боловсруулж 04 дүгээр сарын 16-ны өдрийн дотор ажлын хэсгийг хуралдуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт : 1 файл
--	-----	---	--

202

2.1.14.. Үндэсний хиймэл дагуулын төсөл - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт.(2.Дараах бүтээн байгуулалтын төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхлүүлэхийг дараах Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт:)

“Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн газрын станцын 5 байршилд буюу Улаанбаатар хотын Наран станц, Даланзадгад, Дархан, Чойбалсан, Баян-Өлгий аймгуудын сонгосон байршлуудад (МХС ХХК-ийн салбарууд) Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК, Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спэйс компани, Харилцаа холбооны зохицуулах хорооны инженерүүдтэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн газрын станцын 5 байршилд буюу Улаанбаатар хотын Наран станц, Даланзадгад, Дархан, Чойбалсан, Баян-Өлгий аймгуудын сонгосон байршлуудад (МХС ХХК-ийн салбарууд) байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг "Дойтын булаг" ХХК нь 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэн, дүгнэлтийг ирүүлсэн. Уг дүгнэлтээр тус цэгүүдэд байгаль орчны нөлөөлөл байхгүй гэж гарсан.Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компанитай 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” санамж бичгийн хүрээнд боловсруулсан. Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спэйс компани хооронд байгуулагдах “Харилцаа холбооны модуль, антен, гэтвей станц, сүлжээний удирдлагын газрын сегмент нийлүүлэх” гэрээний төсөл (38 нүүр), “Хиймэл дагуул, хиймэл дагуулын удирдлага хяналтын газрын сегмент нийлүүлэх” гэрээний төсөл (47 нүүр) – ийг 2024 оны 12 дугаар сарын 10-нд англи хэлнээс монгол хэлнээ хөрвүүлэн дуусаж, хянан баталгаажуулахаар 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 03/1193 албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

203

4.5.. Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн нэгдсэн системийг төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-д холбож, хөрөнгө оруулагчдад зориулсан нээлттэй мэдээллийн санг англи болон түгээмэл хэрэглэдэг бусад гадаад хэл дээр бэлдэж байршуулах.

Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн нэгдсэн системийг Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-д холбох, хөрөнгө оруулагчдад зориулсан нээлттэй мэдээллийн санг англи болон түгээмэл хэрэглэдэг бусад гадаад хэл дээр бэлдэхээр судалж байна. Монгол Улсын Шадар сайдын Ажлын албатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

123	204	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	22.1. 22.1.Төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэг загвар бүхий нэгдсэн удирдлагатай болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-тай холбох;	Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж эхэлсэн. Хөгжүүлэлтийг 2025 оны 06 дугаар сарын сарын 03-ны дотор дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. “gov.mn” системийн туршилтын хувилбар (https://demo.gov.mn)-т “Санал, хүсэлт” цонх үүсгэн, олон нийтээс санал авч байна. Мөн “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 3 удаагын нийт 6 цагийн сургалтыг хийсэн.
	205		22.5. 22.5. Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын газрын станц байгуулах бэлтгэл хангах, хиймэл дагуул үйлдвэрлэх, нийлүүлэх гэрээ байгуулах ажлыг эхлүүлэх;	“Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн газрын станцын 5 байршилд буюу Улаанбаатар хотын Наран станц, Даланзадгад, Дархан, Чойбалсан, Баян-Өлгий аймгуудын сонгосон байршлуудад (МХС ХХК-ийн салбарууд) Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК, Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спэйс компани, Харилцаа холбооны зохицуулах хорооны инженерүүдтэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Дархан-Уул аймгийн газрын станц байгуулах байршилд харилцан нөлөөлөл илэрсэн. Тиймээс дахин өөр цэг сонгон, хэмжилт хийхээр төлөвлөгөө гаргасан.“Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул” төслийн газрын станцын 5 байршилд буюу Улаанбаатар хотын Наран станц, Даланзадгад, Дархан, Чойбалсан, Баян-Өлгий аймгуудын сонгосон байршлуудад (МХС ХХК-ийн салбарууд) байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг "Дойтын булаг" ХХК нь 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэн, дүгнэлтийг ирүүлсэн. Уг дүгнэлтээр тус цэгүүдэд байгаль орчны нөлөөлөл байхгүй гэж гарсан.Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спейс компанитай 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулах” санамж бичгийн хүрээнд боловсруулагдсан Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Франц Улсын Талес Алениа Спэйс компани хооронд байгуулагдах “Харилцаа холбооны модуль, антен, гэтвей станц, сүлжээний удирдлагын газрын сегмент нийлүүлэх” гэрээний төсөл (38 нүүр), “Хиймэл дагуул, хиймэл дагуулын удирдлага хяналтын газрын сегмент нийлүүлэх” гэрээний төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-нд англи хэлнээс монгол хэлнээ хөрвүүлэн дуусаж, хянан баталгаажуулахаар хүргүүлж, ажлыг эхлүүлсэн.

	206		22.6 . 22.6. Энэ албан даалгаврын 2.1.14-т заасан төслийг хэрэгжүүлэх хүрээнд хиймэл оюун ухааны чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх, дрон сургалт хөгжүүлэлтийн бүс байгуулах.	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах талаар холбогдох судалгаа хийх, тус бүсийг байгуулахад шаардлагатай дүрэм, журмын төсөл болон үйл ажиллагаанд нэвтрүүлэх санал боловсруулж, туршилтын бүсийн байршлыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/23 дугаар тушаалаар баталсан. Ажлын хэсгийн анхдугаар хурлыг 2024 оны 09 дүгээр сард зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүд холбогдох судалгаа мэдээллээ ирүүлсэн.Тус судалгаануудад үндэслэн "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын Хонхор радио нэвтрүүлэх станцын ашиглалт багатай талбайд дрон туршилтын бүс байгуулах боломжийг судалсан. Үүний дүнд Харилцаа холбооны зохицуулах хороо, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран радио давтамж, радио долгион, цахилгаан соронзон орны нөлөөллийг хэмжихэд “их чадлын нэвтрүүлэгч станцуудаас үүссэн хажуугийн болон зурвасын гаднах цацаргалт илрээгүй, ямар нэгэн гадны нөлөөлөл хэмжигдээгүй. Харин 0.2-3000 МГц радио давтамжийн зурваст ажиллаж байгаа радио нэвтрүүлэгчээс хэмжигдсэн дүйх хавтгай долгионы чадлын нягтын утга нь 2.699 Вт/м2, 78.834 Вт/м2, 6.085 Вт/м2 байгаа нь MNS 5594:2020 “Цахилгаан орон, соронзон орон ба цахилгаан соронзон оронгоос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (0 ГГц-300 ГГц, гэсэн дүгнэлт) стандартын 7 дугаар хүснэгтэд заасан хязгаарлагдмал биш орчинд байгаа хүмүүс бүтэн биеэрээ өртөх нөлөөний хяналтын түвшин болох 10Вт/м2-аас их байгаа тул шаардлагад нийцэхгүй” гэсэн дүгнэлт гарсан. Мөн судалгаагаар тогтоогдсон байршлуудад төрөлжүүлэн байгуулахад шаардлагатай эрх зүйн болон бусад зохицуулалтыг хийх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 01/896 дугаартай албан бичгээр “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) ашиглалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, туршилтын бүс байгуулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал авч байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
	207		1.1.2. 1.1.2.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан (А1), өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх стратеги төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт, тус чиглэлээр эрхлэх салбарын хүрээний стратеги төлөвлөгөө боловсруулж, танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;	Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн ур чадварын шилжилт хийх чиглэлээр гаргах стратеги төлөвлөгөөний судалгааг холбогдох газрын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж байна. Тус чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яамны хариуцсан мэргэжилтэнтэй холбогдож шаардлагатай материал илгээсэн. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас

208	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02	1.1.3. 1.1.3.төрийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн албан хаагч бүр үйл ажиллагааны гүйцэтгэлийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилгоор улирал тутам тайлагнаж хэвшүүлэхийг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт;	Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас чиглэл авахад цахим системд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа тул хүлээгдэж байна.
209		1.1.4. 1.1.4.төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “и-Монголиа”-д суурилсан Засгийн газрын нэгдсэн цахим хуудсыг ашиглалтад оруулж, төрийн байгууллага, албан хаагч хооронд мэдээлэл солилцох, харилцах үйл ажиллагаанд нэгдсэн систем ашиглах нөхцөлийг бүрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт;	Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж эхэлсэн. Хөгжүүлэлтийг 2025 оны 06 дугаар сарын сарын 03-ны дотор дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. “gov.mn” системийн туршилтын хувилбар (https://demo.gov.mn)-т “Санал, хүсэлт” цонх үүсгэн, олон нийтээс санал авч байна. Мөн “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 3 удаагын нийт 6 цагийн сургалтыг хийсэн.
210		2.15. 2.15.Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийг шинээр байгуулах болон өргөтгөн шинэчлэх замаар хүчин чадлыг нэмэгдүүлэхийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт;	Хийгдээгүй. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
211		2.22. 2.22.Хүннү хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан дата төв болон хүлэмжийн хийг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлэх төслийг эхлүүлэхийг Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт;	Хийгдээгүй Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас
212		4.20.1. 4.20.1.хөдөлгөөнт холбооны дараа үеийн 5G технологийг нэвтрүүлэх;	Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5G технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01/813 болон 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/36 албан бичгээр Харилцаа холбооны зохицуулах хороонд чиглэл хүргүүлсэн.
213		4.20.2. 4.20.2.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр кирилл болон үндэсний бичгийн албан ёсны хөрвүүлэгчийг төрийн байгууллагууд ашиглах боломжийг судалж, танилцуулах;	Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлэх”-ээр туссан. Ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан бөгөөд үнэлгээний хороо байгуулж, худалдан авах ажиллагааг зарлахаар ажиллаж байна.

	214		4.20.3. 4.20.3.олон улсын байгууллагатай хамтран Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшнийг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж гаргах;	Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааг Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын төвтэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд зохион байгуулж, үр дүнг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцуулсан. Кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг ахиулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжүүдийг судалгааны тайланд тусгасан.
125	215	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02	4.20.4. 4.20.4.Засгийн газрын нэгдсэн вэб хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж, ашиглалтад оруулах.	"Засгийн газрын нэгдсэн веб gov.mn цахим хуудсыг Е-Монголиа төрийн үйлчилгээний цахим платформд үндэслэн хөгжүүлж эхэлсэн. Хөгжүүлэлтийг 2025 оны 06 дугаар сарын сарын 03-ны дотор дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. "gov.mn" системийн туршилтын хувилбар (https://demo.gov.mn)-т "Санал, хүсэлт" цонх үүсгэн, олон нийтээс санал авч байна. Мөн "Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулан, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн цахим хуудасны үйл ажиллагааг хариуцан ажилладаг албан хаагч нарт танхимаар болон цахим хэлбэрээр 3 удаагын нийт 6 цагийн сургалтыг хийсэн." Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас